Үгийн нөөцийн тоо хэмжээг тогтооход Nation нарын 1983 онд анх боловсруулж 1990 онд сайжруулсан тест (Nation, 2001) өнөөдөр хамгийн өргөн хэрэглэгддэг. Энэхүү тестийн найдвартай байдлыг шалгаж судалгаандаа ашигласан сүүлийн үеийн судлаачид суралцагчийн үгийн нөөцийг тогтоох үйл ажиллагаанд шинэлэг, тестийн загвар талаасаа сонирхолтой шийдлүүдийг агуулсан хэмээн үнэлсэн байдаг. Nation, Beglar нарын боловсруулсан үгийн нөөцийн мэдлэг шалгах тест нь унших чадварыг урьдчилан таамаглах өндөр чадвартай болохыг хэдэн зуун судлаачдын бүтээлээс харж болно. Үгийн нөөц (Vocabulary Knowledge) гэх ухагдахууныг хамгийн анх Cronbach (1942) “үгийг тодорхойлох, олон салаа утгыг нь мэдэх болон ашиглахад тохиромжтой нөхцөл байдлыг таних чадвар” гэж тодорхойлсон байдаг. Түүнээс хойш энэ чиглэлээр илүү олон судалгаа хийгдсэн бөгөөд дуудлага, зөв бичгийн мэдлэг, утгын олон талт шинж чанар, холбоо үг бүтээх байдал гэх мэт бусад хүчин зүйлс зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг хүлээн зөвшөөрч эхэлсэн байдаг (Laufer, 1992) (Nagy W. E., 1987) (Read, 2000). Эдгээрийг харгалзан Nation үгийн мэдлэг нь нэгдүгээрт, хэлбэр (аман болон бичгийн); хоёрдугаарт, утга; гуравдугаарт, хэрэглээ гэсэн үндсэн гурван хэмжигдэхүүнээс бүрддэг гэж үзсэн. Түүний энэхүү таамаглал нь Perfetti-ийн үг зүйн чанарын таамаглал дахь үг зүйн мэдлэг гэсэн нэр томъёотой маш төстэй юм (Perfetti, 1985). Түүний тодорхойлолтоор үг зүйн мэдлэг гэдэг нь суралцагч тухайн үгийн хэлбэр, утга, хэрэглээний талаар хэр зэрэг мэдэж байгаа вэ гэдгээр хэмжигдэнэ гэсэн санаа юм. Anderson, Freebody нар анх удаа үгийн мэдлэгийг “өргөн ба гүн мэдлэг” гэсэн хоёр хэмжигдэхүүнд ангилж хуваасан. Үгийн өргөн мэдлэг нь суралцагчийн мэдэж буй үгийн тоо буюу хэмжээгээр илэрхийлэгддэг бол гүн мэдлэг нь тодорхой тооны үгийг хэр сайн буюу хэр гүн гүнзгий мэдэж байгаа вэ гэдгээр хэмжигддэг байна (Anderson, 1981). Суралцагч ялгаатай нөхцөл байдлуудад тухайн үгтэй

олон дахин тааралдаж, тааралдах бүртээ тухайн үгийн бичиглэл, дуудлага, үүсмэл үг болон холбоо үг бүтээсэн байдал, дүрмийн үүрэг зэрэг олон төрлийн хэрэглээтэй танилцаж, мэдлэг хуримтлуулснаар үгийн нөөцөө баяжуулдаг. Өөрөөр хэлбэл тухайн үгтэй аль болох олон дахин тааралдах оролдлогыг тасралтгүй хийх нь чухал бөгөөд ингэснээр цаашид өөрөө үгийн мэдлэгээ хэрэглэх чадвар, дадал нь дээшлэх боломжтой (Nation I. S., Teaching & learning vocabulary, 1990) хэмээжээ.

Хүснэгт 1. Үгийн мэдлэгийн бүрдүүлбэр (Nation, 2001)

Үгийн хэлбэр	Ярианы хэлэнд	Х.А.И	Энэ үг яаж сонсогддог вэ? Энэ үг яаж дуудагддаг вэ?
	Бичгийн хэлэнд	Х.А.И	Энэ үг хэрхэн харагддаг вэ? Энэ үг хэрхэн үсэглэгддэг вэ?
	Үгийн хэсэг	Х.А.И	Энэ үгний хамгийн танигдахуйц хэсэг нь аль вэ? Энэ үгний үндсэн утгыг илэрхийлэхэд аль хэсэг нь чухал вэ?
Үгийн утга	Хэлбэр ба утга	Х.А.И	Энэ үгийн хэлбэр нь ямар утгыг илэрхийлэх дохио вэ? Үндсэн утгыг илэрхийлэхийн тулд ямар үгийн хэлбэрийг ашиглаж болох вэ?
	Ерөнхий агуулга	Х.А.И	Үгийн үндсэн агуулга нь юу вэ? Үндсэн агуулгад өөр юу багтаж болох вэ?
	Холбоотой утга	Х.А.И	Энэ үгтэй тааралдаад өөр ямар үгнүүд санаанд бууж байна вэ? Энэ үгний оронд өөр ямар үгнүүдийг ашиглаж болох вэ?
Үгийн хэрэглээ	Дүрмийн хэрэглээ	Х.А.И	Энэ үг ихэвчлэн өгүүлбэрт ямар байдлаар өгөгдсөн байдаг вэ? Энэ үгийг бид өгүүлбэрт ямар байдлаар ашиглах ёстой вэ?
	Холбоо үг бүтээх байдал	Х.А.И	Ямар төрлийн үгнүүд энэ үгтэй хамт ихэвчлэн хэрэглэгддэг вэ? Энэ үгийг бид бусад ямар үгстэй хамт ашиглах ёстой вэ?
	Хэрэглээний хязгаарлалт	Х.А.И	Бид хэзээ, хаана, ямар нөхцөлд ихэвчлэн энэ үгтэй тааралддаг вэ? Бид энэ үгийг хэзээ, хаана, ямар нөхцөлд ашиглах ёстой вэ?

Тайлбар. Х.А – хүлээн авах мэдлэг; И – илэрхийлэх мэдлэг

Судлаач Read (Read, 2000) үгийн гүн мэдлэгийг утгын нарийвчилсан мэдлэг, цогц мэдлэг, уялдаа холбоот мэдлэг гэсэн гурван хэсгээс бүрдэж болно гэж үзсэн бөгөөд ингэснээр хэмжигдэхүүнүүдийг боловсруулахад илүү хялбар болсон байна. Гэсэн хэдий ч гурван хүчин зүйл тус бүр нь үгийн гүн мэдлэгийг хэмжихэд хязгаарлагдмал бөгөөд давхцсан тохиолдолд үнэн зөв үр дүнг гаргах боломжгүй хэвээр байна. Үгийн гүн мэдлэгийн хэмжүүр болон холбоотой үгсийн хэмжүүр нь үгийн гүн мэдлэгийг хэмжих зорилготой боловсруулагдсан тестүүд бөгөөд уламжлалт судлагдахууны хувьд сайжруулалт хийгдсэн хувилбарыг судлаачид ашиглаж улам хөгжүүлсээр ирсэн (Wesche & Paribakht, 1994), (Read, 2000). Read (2004) үгийн гүн мэдлэгийг утгын нарийвчилсан мэдлэг, цогц мэдлэг, уялдаа холбоот мэдлэг гэсэн гурван хэсгээс бүрдэж болно гэж үзсэн бөгөөд ингэснээр хэмжигдэхүүнүүдийг боловсруулахад илүү хялбар болсон байна. Гэсэн хэдий ч гурван хүчин зүйл тус бүр нь үгийн гүн мэдлэгийг хэмжихэд хязгаарлагдмал бөгөөд давхцсан тохиолдолд энэхүү судалгаанд үнэн зөв үр дүнг гаргах зорилгоор Wesche & Paribakht нарын боловсруулсан (VKS) (Wesche & Paribakht, 1994) үгийн гүн мэдлэгийг доорх асуулгаар илрүүлдэг тестийг хамт ашигласан:

1. Би энэ үгтэй өмнө нь тааралдаж байсан эсэхээ санахгүй байна.

2. Би энэ үгтэй өмнө нь тааралдаж байсан хэдий ч утгыг нь санахгүй байна.
3. Би энэ үгтэй өмнө нь тааралдаж байсан, энэ үг _____ утгатай.
4. Би энэ үгийн утгыг мэднэ. Энэ үг өөр бас _____ утгатай.
5. Би энэ үгийг ийм өгүүлбэрт оруулж ашиглаж чадна: _____.

Дээрх хэмжээс ба оноонууд нь оролцогчдын үгийн мэдлэгийг үгийн утга болон үгийн хэлбэрийн талаар ерөнхийлөн харуулж байгаа бөгөөд дүрмийн мэдлэг, холбоос утга гэх мэт бусад хэлэхүйн чадварын бүрдэл хэсгийг бүрэн хэмжих боломжгүй байгаа юм. Харин холбоотой үгсийн хэмжүүр нь хэлбэр, утга, ерөнхий агуулга гэсэн гурван талын мэдлэгийг хэмжиж байж тухайн үгийг хэр түвшинд мэдэж байгаад үнэлгээ өгөх боломжтой.

Судалгааны зорилго


Дээрх судлагдсан байдал болон суралцагчийн үгийн нөөцийг хоёр хувилбараар тогтоох боломжид үндэслэн энэхүү судалгаагаар дараах зүйлсийг тодруулахаар зорьлоо. Үүнд:

1. Академик IELTS-ийн унших шалгалтын гүйцэтгэл нь суралцагчийн үгийн нөөцийн өргөн ба гүн мэдлэгээс хамаарч байна уу?
2. Академик IELTS-ийн унших шалгалтын ялгаатай даалгавруудын гүйцэтгэл нь суралцагчийн үгийн нөөцийн өргөн ба гүн мэдлэгээс хамаарч байна уу?

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд 17-29 насны 42 монгол суралцагчийг англи хэлний албан бус сургалтын төвд IELTS-ийн шалгалтанд бэлтгэх сургалтанд хамрагдаж байх үед нь санал тавьж санамсаргүй түүврийн аргаар сонгож судалгаанд оролцуулсан. Оролцогчид өмнө нь англи хэлийг төрөлх хэлнийхээ орчинд Монгол улсын боловсролын эрх бүхий байгууллагаас баталсан албан сургалтын хөтөлбөрийн дагуу 8-аас дээш жил судалсан байсан. Судалгаанд оролцогчдын 14 нь дундын анхан шатны анги, 22 нь дунд шатны анги, 6 нь ахисан дунд шатны ангийн суралцагч байсан. Эдгээр оролцогчид бүгд IELTS шалгалтанд бэлтгэх 80 цагийн дадлага хөтөлбөрт хамрагдсан учир тус шалгалтын даалгаварууд, түүнийг хэрхэн гүйцэтгэх талаар бүрэн ойлголттой болсон байв. Оролцогчдын англи хэлний түвшинг IELTS-ийн жишиг шалгалтын дүнд үндэслэн тогтооход Европын үнэлгээний нийтлэг шалгуураар (CEFR) A2-C1 хооронд буюу 3 өөр түвшиний бүлэг нь энэхүү судалгааны өгөгдөл цуглуулахад тохирсон түүвэр гэж үзсэн.

Дээр дурьдагсан үзэл баримтлалын хүрээнд судалгаанд оролцогчдын үгийн өргөн ба гүн мэдлэгийг тодорхойлох дараах загварчлалын дагуу судалгааг хэрэгжүүлсэн.



Зураг 1. Судалгааны дизайн

Үгийн нөөцийн өргөн мэдлэгийг тодорхойлоход Nation, Beglar нарын 1983 онд боловсруулж 1999 онд Beglar & Hunt, 2001 онд Schmitt, Schmitt, & Clapham нарын сайжруулан баталгаажуулсан Vocabulary Size Test (VST) тестийн 2007 оны нэг хэлний хувилбарыг ашигласан. Оролцогчдын англи хэлний түвшинг харгалзан үгийн нөөцийг 14 мянган үг хүртгэл оношлоход зориулан бүтээгдсэн уг тестээр эхний 10 мянган үгийн хүрээнд шалгаж тогтоосон ба тестийн жишиг даалгавар нь дараах байдлаар харагдана. Энгийн богино өгүүлбэр өгөгдөнө. Уг өгүүлбэр дэх *ташуу, тодоор* бичигдсэн үгийн утгыг илэрхийлсэн тайлбар мэдээллийг доорх хариултуудаас сонгоно.

Please *write* it here.

- move to a new place
- make words on paper
- cut into pieces
- make something better
- I don't know

Найдвартай байдал нь 0.96 -тай шалгагдсан уг цахим тест дэх үг бүр нь 100 үгийг төлөөлөх нийт 10.000 үгийн мэдлэгийг 100 үгээр хэмжих ба зөвхөн уншиж ойлгох чадварт нөлөөлөх үгийн сангийн мэдлэгийг хэмжих зорилготой болохыг Nation анхааруулсныг дурьдах нь зүйтэй (Nation P. , 2012). Шалгуулагч нь өгүүлбэр дэх тодруулсан үгийн утгатай нийцэх үгийг өгөгдсөн 4 үгийн жагсаалтаас сонгоно. Шалгуулагч өгөгдсөн хариултын сонголтоос шалгагдаж байгаа үгийн утгыг таньж таах боломжгүй байхаар боловсруулагдсан нь уг тестийн онцлог юм. Хэрэв өгөгдсөн үгийг танихгүй, утгыг нь огт мэдэхгүй бол “Би мэдэхгүй байна.” гэсэн хариултыг сонгоно.

Дараагийн мэдээлэл цуглуулах өөр нэг хэрэгсэл болох Read-ын 1998 онд боловсруулсан Words Associate тестийг оролцогчдын үгийн нөөцийн гүн мэдлэгийг хэмжих зорилгоор ашигласан. Энэхүү тест нь 35 минутын хугацаанд өгөгдсөн 40 үг тус бүрийг дагалдуулсан 8 үгнээс утга ойролцоо утга болон хорших утгыг тохируулан харгалзуулсан 4-ийг сонгох даалгавартай ба тус судалгаанд 40 асуултаас 25-ыг нь авч хураангуйлсан ба тестийг кронбахын альфа коэффициентоор найдвартай байдлыг (.911) шалгасан. Тестийн жишиг болгож хоёр даалгавар харуулав.

Synonym	Collocation
1. fine	
excellent average constant natural	day athlete removal china
2. bright	
clever famous happy shining	color hand poem taste

Мэдээлэл цуглуулах сүүлийн хэрэгсэл болох унших чадвар шалгахдаа IELTS-ийн шалгалтанд бэлтгэгчдэд зориулан гаргадаг цувралын Cambridge IELTS 9 (ESOL, IELTS 9, 2013), Cambridge IELTS 8 (ESOL, IELTS 8, 2011) дугаарын 1,2-р тестээс тус бүр 1 ба 3-р эхийг сонгон ашигласан. Эх тус бүр 1350-1500 орчим үгтэй, нийт 27 асуулт бүхий, хялбар ба хүнд түвшний унших чадвар шаардсан Мэдээллийн үнэн, худал, өгөгдөөгүй болохыг олох-True/False/Not Given (TF), Асуултанд 2-3 үгээр хариулах-Short (Answer Questions (SAQ), Дэд гарчиг тааруулах-Matching Headings (MH), Олон сонголтоос зөв хариултыг олох-Multiple Choice (MC), Өгүүлбэрийг гүйцээх-Sentence Completion (SC) гэсэн 5 төрлийн даалгавартай шалгалтын жишиг даалгаваруудаас бүрдсэн байсан. Судалгааны өмнө, дээр дурьсанчлан албан бус сургалтын төвийн цөөн гишүүнтэй хэсгийн 8 суралцагчаас авсан

туршилт судалгаанд үндэслэн үгийн нөөцийн 2 тестийн агуулгыг хураангуйлж авсан нь судалгааны үр дүнгийн найдвартай байдалд нөлөөлөхгүй болохыг тогтоосон. Оролцогчид үгийн нөөцийн өргөн мэдлэгийн тест (20 минут), үгийн нөөцийн гүн мэдлэгийн тест (30 минут), IELTS-ийн 2 эх унших тест (40 минут) нийт 90 минутын хугацаанд хийж гүйцэтгэсэн. Судалгааны статистикаар үгийн нөөцийн өргөн мэдлэг (Vocabulary Size Test - VS), үгийн нөөцийн гүн мэдлэг (Vocabulary Depth Score - VD), үгийн утга таних мэдлэг (Word Associates Format - WAF) гэсэн 3 төрлийн тестийн тоон өгөгдлийг цуглуулсан. Түүнчлэн IELTS-ийн эх уншиж хариулах TF, SAQ, MH, MC, SC гэсэн 5 төрлийн даалгаварын 27 асуултанд хариулсан оноог цуглуулсан. WAF ба VKS тестүүд нь хоёулаа оролцогчийн үгийн нөөцийн гүн мэдлэгийг хоёр өөр үзүүлэлтээр хэмжиж байгаа учир нийлээд 100 оноо байхаар онооны үзүүлэлтийг тохируулсан. Цуглуулсан тоон өгөгдлүүдийг IBM SPSS 23 програмд оруулан боловсруулж, үр дүнд дүрслэх болон дүгнэх шинжилгээнүүд хийсэн.

Хүснэгт 2. IELTS ба Үгийн нөөцийн хамаарал

Spearman's Correlations			
	VS	VD	WAF
IELTS	.51***	.62***	.62***

*** $p < .001$ (two-tailed). (Корреляци нь 0.01 түвшинд чухал ач холбогдолтой)

Хувьсагчуудын тархалтыг Kolmogorov-Smirnov болон Shapiro-Wilk-ын тестээр хамтад нь шалгаж үзэхэд үгийн нөөцийн өргөн мэдлэгийн тест (VST)-ийн үр дүн хэвийн тархалттай буюу үгийн нөөцийн өргөн мэдлэг, үгийн нөөцийн гүн мэдлэг нь IELTS-ийн унших чадварын онооны үзүүлэлтүүдийн хамаарлын коэффициент .51 байгаа нь хүчтэй хамааралтай гарсан байна. Нийт 6 үл хамаарах хувьсагчийн төлөөлөх чадварын үзүүлэлт 62 байгаа нь хамгийн бага түүврийн утгыг бүрэн хангаж олон регрессийн шинжилгээ хийх боломжтойг илтгэж байна.

Хүснэгт 3-т судалгаанд оролцогчдын үгийн өргөн мэдлэг (VS), үгийн гүн мэдлэг (VD), үгийн гүн мэдлэгийн оноо (WAF), IELTS-ийн унших чадварыг 5 өөр даалгавараар шалгасан онооны стандарт хазайлт болон дундаж утгыг харагдаж байна.

Хүснэгт 3. Бүх үзүүлэлтийн дүрслэх статистик

	Minimum score	Maximum score	Maximum possible score	Mean	Std. Deviation
VS	32	94	100	67.81	15.16
VD	45.23	92.34	100	68.05	13.18
WAF	42	91	100	74.28	12.26
VKS	44	119	123	78.96	20.13
IELTS	3.1	26	28	17.24	6.09
TF	0	6	7	4.46	1.67
SAQ	0	6	4.55	1.94	1.68
MH	0	6	7	3.96	1.92
MC	0	4	4	2.46	1.46
SC	0	4	4	1.75	1.38

Дээрх хүснэгтээс оролцогчийн үгийн өргөн мэдлэг TF гэх мэт мэдээлэл буюу хариулт нь эх дотроо ил тодорхой байдаг даалгаваруудыг амжилттай гүйцэтгэхэд хүчтэй хамааралтай байгаа нь тодорхой харагдаж байна. Харин MH, MC гэх мэт уншигч гол мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх гэх мэт оюуны гүнзгий түвшний үйлийн үрээр эхэд байгаа далд мэдээлэлд боловсруулалт хийх замаар зөв хариултыг сонгоход оролцогчийн үгийн гүн мэдлэг

шаардлагатай болох нь харагдаж байна. Түүнчлэн, оролцогч үг болон, холбоо үгээр хариулах шаардлагатай SAQ and SC гэсэн даалгаваруудын гүйцэтгэл тэдний үгийн гүн мэдлэгтэй мөн хүчтэй хамааралтай байгаа нь харагдсан.

Хүснэгт 4. Унших даалгаварын гүйцэтгэл үгийн мэдлэгийн хамаарал

Даалгаварын төрөл	Үгийн өргөн мэдлэг /VS/	Үгийн гүн мэдлэг /VD/
Мэдээллийн үнэн, худал, өгөгдөөгүй болохыг олох /TF/	.43***	.16
Асуултанд 2-3 үгээр хариулах /SAQ/	.42**	.51***
Дэд гарчиг тааруулах /MH/	.48***	.62***
Олон сонголтоос зөв хариултыг олох /MC/	.35**	.52***
Өгүүлбэрийг гүйцээх /SC/	.44***	.47*

* $p < .05$, ** $p < .01$, *** $p < .001$ (two-tailed).

Оролцогчийн үгийн тоо буюу өргөн мэдлэг нэмэгдэхэд унших чадвар дээшилж байгаа эсэхийг тогтоохын тулд олон регрессийн шинжилгээ хийсэн. Үүний тулд оролцогчдоос авсан үгийн өргөн мэдлэгийн тестийн үр дүнг төлөөлөх чадвартай түүврийг 3,000–3,999, 4,000–4,999 гэх мэтээр 9,000–10,000 үгийн нөөцтэй гэсэн байдлаар эрэмбэлж VS30, VS40, VS50, VS60, VS70, VS80, VS90S гэж кодлон 7 dummy хувьсагч тодорхойлсон. Оролцогчдийн хамгийн бага үгийн нөөц 3000-с эхэлж байсан тул эхний хувьсагчийг VS30 гэж кодлосон нь 3,000–3,999 үгийн нөөцтэйг харуулж байгаа ба дараагийн нь VS40 кодтой буюу 4,000–4,999 нөөцтэй гэх мэтээр кодлосон. (хүснэгт 5) IELTS-ийн унших чадварын оноо үл хамаарах хувьсагчаар авч үгийн гүн мэдлэг VD болон үгийн өргөн мэдлэг буюу тоо (VS30, VS50, VS60, VS70, VS80 and VS90 кодтой хамаарах хувьсагч) -с хэрхэн хамаарч байгааг Олон регрессийн шинжилгээг хийхдээ тогтоосон. VS30, VS40 хэмжээ бүхий үгийн нөөцтэй оролцогч түүврийн чанар хангаагүй буюу тус бүр 2 оролцогч байсан учир хассан.

*Хүснэгт 5. Олон регрессийн коэффициент**

Стандарт бус коэффициент			Стандарт коэффициент		
Model	B	Std. Error	Beta	t	Sig.
1 (Constant)	-3.171	4.635		-.687	.495
VD	.298	.076	.439	4.005	.000
VS50	9.049	3.004	.357	3.010	.004
VS60	11.306	2.989	.518	3.784	.000
VS70	7.947	3.247	.364	2.454	.018
VS80	12.675	2.948	.596	4.287	.000
VS90	13.165	4.196	.318	3.148	.003

* Хамаарах хувьсагч: IELTS scores

Олон регрессийн шинжилгээний үр дүн үгийн өргөн ба гүн мэдлэгийн түвшин унших чадвартай шууд хамааралтай болох нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Хязгаарлагдмал хүрээнд хийгдсэн энэхүү судалгааны үр дүнгээс харахад үгийн өргөн ба гүн мэдлэг хоёр хоорондоо хүчтэй хамааралтай байна. Энэ үзүүлэлт нь үгийн гүн мэдлэг сайтай байх нь суралцагчийн уншиж ойлгох төдийгүй англи хэлний хэлэхүйн бусад чадварын хөгжилд ч чухал нөлөөтэй болохыг харуулж байна. Түүнчлэн, энэхүү судлагааны үр дүн Qian болон Kirby нарын үгийн өргөн ба гүн мэдлэг, унших чадвар хоорондоо хүчтэй хамааралтай буюу суралцагч хэдий чинээ олон үг шинээр мэддэг болох тусам уншиж буй эхийг ойлгох боломж нэмэгдэнэ гэсэн дүгнэлтүүдээр нотлогдож байна. Ингэснээр эхийн санааг бүрэн ойлгоход саад болж байгаа мэдэхгүй үгийн утгыг таах, үг зүйн болон өгүүлбэр

зүйн харьцаагаар нь үгийн нөөцийн мэдлэг нь гүнзгийрэх замаар урт хугацааны санах ойд хадгалагддаг байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах 2 саналыг дэвшүүлж байна.

1. Англи хэл суралцагчдын үгийн нөөцийг өргөн ба гүн мэдлэг гэсэн хэмжээсээр нарийн хэмжиж тогтоох, хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйд оновчтой тусгах нь сургалтын үр дүнг дээшлүүлэхэд эерэг нөлөөтэйг харгалзаж үзэх
2. Цаашид үгийн гүн ба өргөн мэдлэг, унших чадвар гэсэн хувьсагчуудыг хэлзүйн мэдлэг, төрөлх хэлээрээ унших арга барил зэрэг хамаарах хувьсагчаар баяжуулан илүү өргөн хүрээнд судалж үзэх боломжтой гэж үзсэн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Anderson, R. C. (1981). Vocabulary knowledge. In J. G. (Ed.), *Comprehension and teaching: Research reviews* (pp. 77-117). Newark, Del.: International Reading Association.
- Beglar, D. (2010). A rasch-based validation of the vocabulary size test. *Language Testing*, 27(1), 101-118.
- Bruce Taylor, D. M. (2009). Using explicit instruction to promote vocabulary learning for struggling readers. *Reading & Writing Quarterly*, 205-220.
- Chapelle, C. (2001). A Framework for Second Language Vocabulary Assessment. *Language Testing*, 18, 1-32.
- Coxhead, A. (2000). "A new academic Word List". *TESOL*, 181.
- Henriksen, B. (1999). Three dimensions of vocabulary development. In *Studies in Second Language Acquisition 21* (pp. 303–317).
- Hu, M. &. (2000). Vocabulary density and reading comprehension. *Reading in a Foreign Language*, 13(1), 403–30.
- Huckin, T. &. (1999). Incidental vocabulary acquisition in a second language. In *Studies in second language acquisition* (21(02) ed., pp. 181-193). Cambridge University Press.
- Laufer, B. (1992). How much lexis is necessary for reading comprehension. *Vocabulary and Applied Linguistics*, 126-132.
- Lee, S. H. (2003). ESL learners' vocabulary use in writing and the effects of explicit vocabulary instruction. *System*, 31(2), 537-561.
- Li, M. &. (2014). The effects of vocabulary breadth and depth on English reading. *Applied Linguistics*, 7, 1-25.
- Nagy, W. E. (1987). Breadth and depth of vocabulary knowledge: Implications for acquisition and instruction. In *The Nature of Vocabulary Acquisition* (Vol. 19, p. 35).
- Nagy, W. E. (1988). Teaching vocabulary to improve reading comprehension. Illinois: National Council of Teachers of English.
- Nassaji, H. (2006). The Relationship Between Depth of Vocabulary Knowledge and L2 Learners' Lexical Inferencing Strategy Use and Success. *The Modern Language Journal*, 387 - 401.
- Nation, I. S. (1990). *Teaching & learning vocabulary*. Rowley, MA: Newbury House.
- Nation, I. S. (2004). *A study of the most frequent word families in the British National Corpus* (Vol. 21).
- Nation, P. &. (2009). Teaching and testing vocabulary. In M. &. In Long, *The handbook of language teaching* (pp. 536-559). Sussex: Blackwell Publishing.
- Nation, P. (1994). *Teaching and learning vocabulary*. New York: Newbury House.

- Nation, P. (2012). Measuring vocabulary size in an uncommonly taught language. *In International Conference on Language Proficiency Testing in the Less Commonly Taught Languages*.
- Qian, D. D. (1999). Assessing the roles of depth and breadth of vocabulary knowledge in reading comprehension. *Canadian Modern Language*, 56(2), 282-308.
- Qian, D. D. (2002). Investigating the relationship between vocabulary knowledge and academic reading performance: An assessment perspective. *Language learning*, 52(3), 513-536.
- Richards, J. C. (1976). The Role of Vocabulary Teaching. *ESOL Quarterly*, 10, 77-89.
- Saragi, T. N. (1978). Vocabulary learning and reading. *System*, 6(2), 72-78.
- Sternberg, R. J. (1987). Most vocabulary is learned from context. In M. G. (Eds.), *The nature of vocabulary acquisition* (pp. 89–105). Lawrence Erlbaum Associates, Inc.
- Zhang, L. J. (2008). The Role of Vocabulary in Reading Comprehension The Case of Secondary School Students Learning English in Singapore. *RELC Journal*, 39(1), 51-76.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛЫН ҮР ДҮНГИЙН АСУУДАЛД

О.Баттуяа¹, М.Ганхөлөг², Ц.Цолмон³, Ө.Гангамаа⁴

¹Мандах их сургуулийн СШУИТ-н багш battuya@mandakh.edu.mn

²Мандах их сургуулийн СШУИТ-н багш gankhulug@mandakh.edu.mn

³Мандах их сургуулийн СШУИТ-н багш tsolmon.ts@mandakh.edu.mn

⁴Мандах их сургуулийн СШУИТ-н багш gangamaa@mandakh.edu.mn

Хураангуй

Дэлхийн улс орнууд 1800 оноос хойш хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо мэдээллийг цуглуулж эхэлсэн бөгөөд сүүлийн 60 жилд энэ төрлийн мэдээллийг цуглуулах улс орны тоо нэмэгдэж байна. АНУ, Энэтхэг болон Португал зэрэг улсууд 19 дүгээр зууны туршид хүн амын тооллогын асуулгадаа хөгжлийн бэрхшээлийн асуултыг оруулж судалсан түүхтэй байдаг. Өнөөгийн байдлаар дэлхийн 198 улс орнууд 700 гаруй тооллого, өрхөд суурилсан түүвэр судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг гаргаж байна¹.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг албан ёсны статистик болон захиргааны бүртгэл мэдээллийг авч ашиглаж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийн асуудал нь олон салбарт хамаарагдах асуудал учраас салбар бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тоо мэдээллийг гаргахад чиглэгдэж байна.

Монгол улсын статистик мэдээллийн санд 2003 оны байдлаар 60435² хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн бол 2022 онд 115115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдэж сүүлийн 20 жилийн хугацаанд 47,5% иар буюу 54680 өссөн үзүүлэлттэй байна. Энэ талаар судалгаа их байгаа бодит үр дүнд хүрэхгүй байгаа нь харагдаж байна. Бид статистик тоон мэдээлэл дээр анализ хийн үр дүнд хүрэх тэр өнцөг нь хаана вэ гэдгийг харахын тулд уг судалгааг хийлээ.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээ, Хараа, Хөдөлгөөн, Сэтгэц, Судлал, Зорилго

Бид дээрх статистик мэдээллээс үндэслэн өнгөрсөн 2003-2022 жилийн статистик мэдээллийг 3 жилийн давтамжтайгаар авч үзэн иргэдийн дүгнэлт хийж дараагийн 5 жилүүдэд аль төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд давамгайлах магадлалтай байна гэдгийг таамаглах, улмаар урьдчилан сэргийлэх боломж буй эсэх талаар тодруулахыг оролдлоо.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Бид энэ илтгэлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон судалгааг 2003-2022 оны 20 жилийн мэдээлэл дээрээ тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийн таван жилийн төлөвийг Eviews программ ашиглан ашиглан прогнозон гаргана.

¹ Ashington group: History of disability measurement and data availability

² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (1212.mn)

Оршил


Хууль зүйн толь бичигт³ хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх нэр томъёог олон улсад(invalidus. Лат., disability. Англ., инвалидность.орос) төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүн гэж тодорхойлж байна. Хөгжлийн бэрхшээл гэх ойлголт нь нийгмийн хөгжлийн онцлогийг даган өөрчлөгдөн хувьсаар ирсэн бөгөөд социалист нийгмийн үед уг нэр томъёог явцуу утгаар тахир дутуу хүн гэж нэрлэж байсан бол 1990 оноос хойш буюу хүний эрх, эрх чөлөөг дээдлэгч ардчилал тогтсон үеэс манай улсад тахир дутуу гэх ойлголтыг илүү өргөн цар хүрээгээр, хүмүүнлэгийн үүднээс нухацтай авч үзэн “хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно” хэмээн тодорхойлох болсон байна.

Судалгааны материал

Монгол улсын Үндэсний статистик мэдээллийн санд 2022 оны байдлаар 115,115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн байна. Үүнд:

- Харааны бэрхшээлтэй иргэн: 12,696
- Ярианы бэрхшээлтэй иргэн: 4,220
- Сонсголын бэрхшээлтэй иргэн: 8,780
- Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэн: 21,064
- Оюун ухааны хомсдолын бэрхшээлтэй иргэн: 0
- Сэтгэцийн бэрхшээлтэй иргэн: 21,639
- Хавсарсан бэрхшээлтэй иргэн: 7,580
- Бусад: 39,136

тоон үзүүлэлтийг доорх зургаар илэрхийлэв.




Зураг 1. 2022 оны 12-р сарын байдлаарх нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон үзүүлэлт

Сүүлийн 20 жилийн тоон үзүүлэлтийг хүснэгтэн хэлбэрээр доорх байдлаар харуулав. Үүнээс харахад 2006, 2016 онуудад нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо багассан харагдаж байна. Энэ нь 10 жилд ганц удаа тохиолдож байгаа нь харамсалтай. Мөн ярианы бэрхшээлтэй иргэд эхний 10 жилд бүртгэгдээгүй хэдий ч сүүлийн 10 жилд тасралтгүй

³ Эх сурвалж

бүртгэгдэж байна. Харин сайшаалтай үзүүлэлт болох оюун ухааны хомсдолтой иргэдийн тоо үзүүлэлт сүүлийн арван жил дараалан бүртгэгдээгүй байна.



Зураг 2. Сүүлийн 20 жилийн тоон үзүүлэлтийг 3 жилийн давтамжтайгаар харуулав

Хүснэгт 1. Сүүлийн 20 жилийн тоон үзүүлэлтийг 3 жилийн давтамжтайгаар харуулав

Хөгжлийн бэрхшээл	2003	2004	2005	2009	2010	2011	2015	2016	2017	2021	2022
Бүгд	60435	66225	73001	80796	82631	86865	101730	100993	103630	106169	115115
Харааны	4540	5705	6517	7794	8431	9066	10925	11001	11071	11695	12696
Ярианы							4491	4367	4228	4074	4220
Сонголын	6418	7536	8456	9295	9584	9990	8406	8560	8554	8430	8780
Хөдөлгөөний	9028	10906	12152	15501	15334	16178	20110	20127	20688	21011	21064
Оюун ухааны хомсдолтой	7717	8832	9752	10375	10647	10566					0
Сэтгэцийн	3681	4776	5442	7670	7950	8799	18433	18359	19733	20414	21639
Хавсарсан	5044	6309	6730	8758	8685	9833	7912	8052	7842	7430	7580
Бусад	24007	22161	23952	21403	21834	22433	31453	30527	31514	33115	39136

Харин 2003 оны байдлаар 60435⁴ хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн бол 2022 онд 115115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдэж сүүлийн 19 жилийн хугацаанд 47,5% иар буюу 54680 өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэндийн дундаж өсөлт 2003-2022 он


Д.д	Хөгжлийн бэрхшээлийн төрөл	2003	2022	2003-2022 оны өсөлт	Дундаж өсөлт өсөлт
1	Бүгд	60435	115115	47.50033	2.5
2	Харааны	4540	12696	64.24071	3.38
3	Сонголын	6418	8780	26.90205	1.416
4	Хөдөлгөөний	9028	21064	57.14014	3.01

5	Сэтгэцийн	3681	21639	82.98905	4.37
5	Хавсарсан	5044	7580	33.45646	1.761
7	Бусад	24007	39136	38.6575	2.035

Дээрх хүснэгтээс харахад Хараа, хөдөлгөөн, сэтгэцийн бэрхшээл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлүүдээс орчны стандартаас голлон хамаардаг бэрхшээл гэж үзээд харааны, хөдөлгөөний, сэтгэцийн бэрхшээлүүдийг нарийвчлан авч үзэв.

Оюун санаанд нөлөөлдөг ноцтой өвчний бүлэг юм. Тэд хэн нэгэнд тодорхой сэтгэх, зөв дүгнэлт гаргах, сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлэх, үр дүнтэй харилцах, бодит байдлыг ойлгох, биеэ зөв авч явахад хэцүү болгодог үүнийг **Сэтгэцийн бэрхшээл** гэнэ.⁵

Сэтгэцийн бэрхшээл нь 20 жилийн туршид тасралтгүй өссөн цор ганц бэрхшээл байна. Мөн энэхүү бэрхшээл нь 20 жилийн өмнө хамгийн бага тоон үзүүлэлттэй байсан бол одоо хамгийн их болсон буюу 3681 байснаас 21639 болж 20 жилийн дотор 17958 иргэдээр өссөн байна. Үүнийг доорх графикаар үзүүлээ.



Зураг 3. Сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийг (20 жилээр)

Дээрх үзүүлэлтээс харахад сэтгэцийн хөгжлийн бэрхшээл нь 5 жилийн дунджаар 2003-2007 оны хооронд 3681 байснаас 5855 болж 2174 өссөн байна.

2007-2011 оны хооронд 5855 байснаас 8799 болж 2944 өссөн байна.

2011-2015 оны хооронд 8799 байснаас 18433 болж **9634** өссөн байна.


(энэхүү өсөлт нь 2012-2013 оны хооронд 6460 тоогоор өссөнтэй холбоотой)

2015-2019 оны хооронд 18433 байснаас 20728 болж 2295 өссөн байна.

2019-2022 оны хооронд 20728 байснаас 21639 болж 911 өссөн байна.


5 жилийн дунджаар сэтгэцийн бэрхшээлийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд бүх онуудад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэхүү өсөлт нь ойролцоогоор 2000 гаруй иргэд байна. 2011-2015 оны хооронд 9634 иргэнээр өссөн голлох шалтгаан нь 2012-2013 оны хооронд буюу ганцхан жилийн дотор 6460 тоогоор өссөнтэй холбоотой байна.

⁵ Сандагийн Бямбасүрэн „Сэтгэцийн эмгэг судлал“ УБ 2007




Зураг 4. Хүн амын тоотой харьцуулахад эзэлж буй хувь (5 жилээр)

2003 онд 2,495,091 хүн амтай байсны 3681 хүн нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй буюу нийт хүн амын 0.0014 хувийг эзэлсэн байна. Харин 2022 онд 3,457,548 хүн амын 21639 хүн нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй буюу нийт хүн амын 0.0062 хувийг эзэлсэн байна. 2003 онд 10,000 хүний 14 хүн, 2008 онд 10,000 хүний 25 хүн, 2013 онд 10,000 хүний 56 хүн, 2018 онд 10,000 хүний 62 хүн, 2022 онд 10,000 хүний 62 хүн сэтгэцийн бэрхшээлтэй байна. **Хөдөлгөөний бэрхшээл:** Хөдөлгөөний бэрхшээл нь 20 жилийн өмнө 9028 байснаас 21061 болж 20 жилийн дотор 12033 иргэдээр өссөн байна. Үүнийг доорх графикаар үзүүллээ.



Зураг 5. Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийг (20 жилээр)


Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл нь 5 жилийн дунджаар 2003-2007 оны хооронд 9028 байснаас 12776 болж 3748 өссөн байна. 2007-2011 оны хооронд 12776 байснаас 16178 болж 3402 өссөн байна. 2011-2015 оны хооронд 16178 байснаас 20110 болж 3932 өссөн байна. 2015-2019 оны хооронд 20110 байснаас 21545 болж 1435 өссөн байна. 2019-2022 оны хооронд 21545 байснаас 21064 болж 481 буурсан байна. 5 жилийн дунджаар хөдөлгөөний бэрхшээлийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд ихэнх онуудад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэхүү өсөлт нь ойролцоогоор 3000 гаруй иргэд байна. 2019-2022 оны хооронд 481 иргэнээр буурсан голлох шалтгаан нь тоон үзүүлэлтээ 4 жилээр гаргасантай холбоотой байж болно.



Зураг 6. Хүн амын тоотой харьцуулахад эзэлж буй хувь (5 жилээр)

2003 онд 2,495,091 хүн амтай байсны 9028 хүн нь хөдөлгөөний бэрхшээлтэй буюу нийт хүн амын 0.0036 хувийг эзэлсэн байна. 2022 онд 3,457,548 хүн амтай байсны 21064 хүн нь хөдөлгөөний бэрхшээлтэй буюу нийт хүн амын 0.0060 эзэлсэн байна. 2003 онд 10,000 хүний 36 хүн, 2008 онд 10,000 хүний 51 хүн, 2013 онд 10,000 хүний 62 хүн, 2018 онд 10,000 хүний 66 хүн, 2022 онд 10,000 хүний 60 хүн хөдөлгөөний бэрхшээлтэй байна.

Харааны бэрхшээл: Харааны бэрхшээл нь 20 жилийн өмнө 4540 байснаас 12696 болж 20 жилийн дотор 8156 иргэдээр өссөн байна. Үүнийг доорх графикаар үзүүлээ.



Зураг 7. Харааны бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийг 20 жилээр харуулав

Харааны хөгжлийн бэрхшээл нь 5 жилийн дунджаар

2003-2007 оны хооронд 4540 байснаас 7008 болж 2468 өссөн байна.

2007-2011 оны хооронд 7008 байснаас 9066 болж 2058 өссөн байна.

2011-2015 оны хооронд 9066 байснаас 10925 болж 1859 өссөн байна.

2015-2019 оны хооронд 10925 байснаас 11690 болж 765 өссөн байна.

2019-2022 оны хооронд 11690 байснаас 12696 болж 1006 буурсан байна.

5 жилийн дунджаар харааны бэрхшээлийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд ихэнх онуудад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэхүү өсөлт нь ойролцоогоор 2000 гаруй иргэд байна. 2019-2022 оны хооронд 1006 иргэнээр буурсан голлох шалтгаан нь тоон үзүүлэлтээ 4 жилээр гаргасантай холбоотой байж болно.



Зураг 8. Хүн амын тоотой харьцуулахад эзэлж буй хувь (5 жилээр)


2003 онд 2,495,091 хүн амтай байсны 4540 хүн нь харааны бэрхшээлтэй буюу нийт хүн амын 0.0018 хувийг эзэлсэн байна. 2022 онд 3,457,548 хүн амтай байсны 12696 хүн нь харааны бэрхшээлтэй буюу нийт хүн амын 0.0036 хувийг эзэлсэн байна. 2003 онд 10,000 хүний 18 хүн, 2008 онд 10,000 хүний 27 хүн, 2013 онд 10,000 хүний 32 хүн, 2018 онд 10,000 хүний 35 хүн, 2022 онд 10,000 хүний 36 хүн харааны бэрхшээлтэй байна

Бид дээрх статистик мэдээллээс үндэслэн өнгөрсөн 2003-2022 жилийн статистик мэдээллийг 3 жилийн давтамжтайгаар авч үзэн дүгнэлт хийж дараагийн жилүүдэд аль төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд давамгайлах магадлалтай байна гэдгийг таамаглахын тулд Eviews программ ашиглан прогнозон гаргая.

Хүснэгт 3. 2023-2027 оны өсөлтийг Eviews программ ашиглан гаргав

View	Proc	Object	Print	Name	Freeze	Default	Sort	Edit+/-	Smpl+/-	Compare+/-	Transpose+/-	Title	Sampl	
		BUGDF		HUDF		HARAAF		HAVSF		SETGETSF		SONSGOLF		BUSADF
2003		60435.00		9028.000		4540.000		5044.000		3681.000		6418.000		24007.00
2004		66225.00		10906.00		5705.000		6309.000		4776.000		7536.000		22161.00
2005		73001.00		12152.00		6517.000		6730.000		5442.000		8456.000		23952.00
2006		71053.00		12096.00		6818.000		7403.000		5561.000		8362.000		21421.00
2007		71908.00		12776.00		7008.000		7639.000		5855.000		8511.000		20433.00
2008		76369.00		13700.00		7246.000		8916.000		6730.000		8755.000		21140.00
2009		80796.00		15501.00		7794.000		8758.000		7670.000		9295.000		21403.00
2010		82631.00		15334.00		8431.000		8685.000		7950.000		9584.000		21834.00
2011		86865.00		16178.00		9066.000		9833.000		8799.000		9990.000		22433.00
2012		92263.00		17580.00		9559.000		9732.000		10089.00		10293.00		24992.00
2013		96325.00		18351.00		9559.000		9571.000		16549.00		8055.000		28760.00
2014		99573.00		18411.00		9652.000		10116.00		16997.00		8304.000		30799.00
2015		101730.0		20110.00		10925.00		7912.000		18433.00		8406.000		31453.00
2016		100993.0		20127.00		11001.00		8052.000		18359.00		8560.000		30527.00
2017		103630.0		20688.00		11071.00		7842.000		19733.00		8554.000		31514.00
2018		105565.0		21614.00		11534.00		7288.000		20321.00		8445.000		32064.00
2019		107075.0		21545.00		11690.00		7334.000		20728.00		8585.000		33107.00
2020		108399.0		21810.00		11871.00		7678.000		20742.00		8708.000		33530.00
2021		106169.0		21011.00		11695.00		7430.000		20414.00		8430.000		33115.00
2022		115115.0		21064.00		12696.00		7580.000		21639.00		8780.000		39136.00
2023		118820.7		24041.35		13334.65		8457.742		24614.17		8963.632		36321.10
2024		121536.4		24712.04		13726.62		8502.041		25718.05		8998.135		37171.77
2025		124252.1		25382.73		14118.60		8546.341		26821.93		9032.638		38022.44
2026		126967.7		26053.42		14510.58		8590.640		27925.82		9067.141		38873.11
2027		129683.4		26724.11		14902.55		8634.939		29029.70		9101.644		39723.79

Дээрх 2003-2022 оны мэдээлэлд тулгуурлан 2023-2027 оны өсөлтийн дундаж хурдыг Арифметик дундын аргаар тооцоолов. Дээрх хүснэгтээс харахад Хараа, хөдөлгөөн, сэтгэцийн болон бусад бэрхшээл хамгийн өндөр өсөлттэй байна.



Зураг 9. 2003-2027 оны өсөлтийн дундаж хурдыг үзүүлэв

2003-2022 оны тоон мэдээлэлд тулгуурдан 2023-2027 оны хөгжлийн бэрхшээлийн аль төрөл, хэр нэмэгдэх хандлагатайг дээрх зурагт үзүүллээ. Дээрх өсөлийг 2022 онтой харьцуулахад Хараа-11.2%, хөдөлгөөн-20.5%, сэтгэц- 23.9% өсөх төлөвтэй байна.

Судалгааны ажлын үр дүн

Монгол улс 2022 оны байдлаар нийт 3457548 иргэнтэй түүний 3.329 хувь буюу 115115 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн. Үүнийг 2003 харьцуулбал 54680 буюу 47,5% иар өссөн үзүүлэлттэй байна. Тэр дундаа хөгжлийн бэрхшээлийн төрлийн дундаж өсөлт нь: Хараа- 3.38%, хөдөлгөөн- 3.01%, сэтгэцийн бэрхшээл- 4.368% хамгийн өндөр хувийг эзэлж байна. Цаашид эдгээр үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс энэ бүгдэд нөлөөж буй хүчин зүйлсийг дэлгэрэнгүй судалж бууруулах арга хэмжээ авах нэн шаардлагатай болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Нэгэнт үүссэн хөгжлийн бэрхшээлийн талаар судлах нь зүйтэй. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөхөөс сэргийлэх талаар анхаарах нь ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Олдмол бэрхшээлд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзвэл:

Дэлхийн эрүүл мэндийн “World health rankings”⁶ судалгаанаас харахад Архины хамаарлаар дэлхийд -II, Тархины цус харвалт-II эрэмбэлэгддэг байна. Энэ хөгжлийн бэрхшээлийг үүсгэх магадлалтай гэж таамаглал дэвшүүлж байна.

⁶ [WORLD HEALTH RANKINGS \(worldlifeexpectancy.com\)](https://www.worldlifeexpectancy.com/)

Мөн Монгол улсад 2022 онд зам тээврийн 24121 осолд 3418 өртөж хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна. Зам тээврийн осолд өртөж, хохирсон 3418 хүний 539 буюу 15,8% нь амь насаа алдаж, 2879 буюу 84,2% нь гэмтэл, бэртэл авч эрүүл мэндээрээ хохирсон байна. Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас гэмтэл бэртэл авсан 2879 хүний гэмтлийн зэрэг: 787 буюу 27.3% нь гэмтлийн зэрэг хүндэвтэр, 214 буюу 7.4% нь гэмтлийн зэрэг хүнд гэж тогтоогдсон байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн хохирогсодын биеийн гэмтэл авсан хэсгийн мэдээллээс авч үзвэл:

- Толгой 21,0%,
- Цээж 10,3%
- Хөл 22,6%
- Гар 16,1%
- Нүүр 5,0%
- Хүзүү 4,1 %
- Хэвлий хэсэгт 5,7%
- Биеийн бүх хэсэгт 1,4%,
- Аарцаг, нуруу 13,9% нь гэмтэл авчээ.

Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон 3418 хүний 1896 буюу 55,6% нь Улаанбаатарт, 1522 буюу 44,5% нь орон нутгийн замд бүртгэгдсэн осол байна. Зам тээврийн осолд өртөж хохирсон хүн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 19.6%-иар өсжээ. Дээрх мэдээллээс үзэхэд Зам тээврийн осолд өртсөн хүмүүсийн 21% нь толгой, 22.6% нь хөлдөө бэртэл гэмтэл авдаг байна.⁷ Олдмол бэрхшээлд авто осол нөлөөлдөг нь харагдаж байна. Энэ мэтээр бусад хүчин зүйлийг нь нарийвчлан тодорхойлвол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөхөөс сэргийлж чадна. Энэ талын нарийвчилсан судалгааг жил бүр гаргаж, олдмол хөгжлийн бэрхшээл талаас нь олон нийтэд таниулж байвал зүйтэй гэж үзэв.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын хүн ам 2003 онд 2,495,091 иргэнтэй байсан бол 2022 онд 34575748 иргэнтэй бол тус онтой харьцуулахад 27.89% нэмэгдсэн байна. Харин 2003 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 60435 буюу хүн амын 2,4%-ийг эзэлдэг байсан.

Улсын статистик мэдээн дэх гурван үзүүлэлт дээр тулгуурлан авч үзвэл дараах дүгнэлт хийж болохоор байна. Үүнд: Сэтгэцийн бэрхшээл нь 20 жилийн туршид тасралтгүй өссөн цор ганц бэрхшээл байна. Мөн энэхүү бэрхшээл нь 20 жилийн өмнө хамгийн бага тоон үзүүлэлттэй байсан бол одоо хамгийн их болсон буюу 3681 байснаас 21639 болж 20 жилийн дотор 17958 иргэдээр өссөн байна.

5 жилийн дунджаар сэтгэцийн бэрхшээлийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд бүх онуудад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэхүү өсөлт нь ойролцоогоор 2000 гаруй иргэд байна. Хүн амын тоотой харьцуулахад эзэлж буй хувь үзүүлвэл: 2003 онд 2,495,091 хүн амтай байсны 3681 хүн, нийт хүн амын 0.0014 хувийг 10,000 хүний 14 хүн сэтгэцийн бэрхшээлтэй байсан байна. 2022 онд 3,457,548 хүн амтай байсны 21639 хүн, нийт хүн амын 0.0062 хувийг 10,000 хүний 62 хүн сэтгэцийн бэрхшээлтэй болж нэмэгдсэн байна.

Хөдөлгөөний бэрхшээл нь 20 жилийн өмнө 9028 байснаас 21061 болж 20 жилийн дотор 12033 иргэдээр өссөн байна. 5 жилийн дунджаар хөдөлгөөний бэрхшээлийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд ихэнх онуудад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэхүү өсөлт нь ойролцоогоор 3000 гаруй иргэд байна. Хүн амын тоотой харьцуулахад эзэлж буй хувиар үзүүлвэл 2003 онд 10,000 хүний 36 хүн нь хөдөлгөөний бэрхшээлтэй байсан бол 2022 онд 10,000 хүний 60 хүн хөдөлгөөний бэрхшээлтэй байна.

Харааны бэрхшээл нь 20 жилийн өмнө 4540 байснаас 12696 болж 20 жилийн дотор 8156 иргэдээр өссөн байна. 2003 онд 10,000 хүний 18 хүн харааны бэрхшээл байсан бол 2022 онд 10,000 хүний 36 хүн болж өссөн байна.

⁷ Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлийн эмхэтгэл 2022 он 17-22ху

Бид 2003-2022 оны тоон мэдээлэлд тулгуурдан 2023-2027 оны хөгжлийн бэрхшээлийн аль төрөл, хэр нэмэгдэх хандлагатайг судлаж үзлээ. Уг таамаглаж гаргасан жилүүдийг Дээрх өсөлийг 2022 онтой харьцуулахад Дээрх өсөлийг 2022 онтой харьцуулахад Хараа-11.2%, хөдөлгөөн-20.5%, сэтгэц- 23.9% өсөх төлөвтэй байна. Цаашид эдгээр үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс энэ бүгдэд нөлөөж буй хүчин зүйлсийг дэлгэрэнгүй судалж бууруулах арга хэмжээ авах нэн шаардлагатай болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Нэгэнт үүссэн хөгжлийн бэрхшээлийн талаар судлах нь зүйтэй. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөхөөс сэргийлэх талаар анхаарах нь ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Олдмол бэрхшээлд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзвэл:

Монгол улсад 2022 онд зам тээврийн 24121 осолд 3418 өртөж хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна. Зам тээврийн осолд өртөж, хохирсон 3418 хүний 539 буюу 15,8% нь амь насаа алдаж, 2879 буюу 84,2% нь гэмтэл, бэртэл авч эрүүл мэндээрээ хохирсон байна. Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас гэмтэл бэртэл авсан 2879 хүний гэмтлийн зэрэг: 787 буюу 27.3% нь гэмтлийн зэрэг хүндэвтэр, 214 буюу 7.4% нь гэмтлийн зэрэг хүнд гэж тогтоогдсон байна. Зам тээврийн осолд өртөж хохирсон хүн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 19.6%-иар өсжээ.

Дээрх мэдээллээс үзэхэд Зам тээврийн осолд өртсөн хүмүүсийн 21% нь толгой, 22.6% нь хөлдөө бэртэл гэмтэл авдаг байна.⁸ Олдмол бэрхшээлд авто осол нөлөөлдөг нь харагдаж байна. Энэ мэтээр бусад хүчин зүйлийг нь нарийвчлан тодорхойлвол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөхөөс сэргийлж чадна. Энэ талын нарийвчилсан судалгааг жил бүр гаргаж, олдмол хөгжлийн бэрхшээл талаас нь олон нийтэд таниулж байвал зүйтэй гэж үзэв.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Ashington group: History of disability measurement and data availability
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа 2017 он
3. [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#)
4. [Хөгжлийн бэрхшээлийн төрлүүд – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо \(apdc.mn\)](#)
5. Сандагийн Бямбасүрэн „Сэтгэцийн эмгэг судлал“ УБ 2007
6. Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2022 он 17-22ху
7. [Хүрээлэн буй орчин, агаарын бохирдол | UNICEF Монгол](#)
8. Улаанбаатар хотын агаарын бохирдол (2018 ба 2021 оны харьцуулалт Сурталчилгааны нийтлэл №1 (2021_01)
9. Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлийн эмхэтгэл 2022 он 17-22ху
10. [WORLD HEALTH RANKINGS \(worldlifeexpectancy.com\)](#)

⁸ Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлийн эмхэтгэл 2022 он 17-22ху

ОЮУТНУУДЫН MS-OFFICE ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММЫН МЭДЛЭГ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Д.Булгантамир /Ахлах багш/ bulгаа@mandakh.edu.mn

С.Анхбаяр /Ахлах багш/ ankhaа@mandakh.edu.mn

Судалгааны ажлын үндэслэл

Ажил олгогчдын судалгаагаар төгсөгчдөөс тавьж буй нэгэн шаардлага нь компьютерийн хэрэглээний чадварыг сайжруулах, ахисан түвшний Excel орох гэсэн саналын дагуу компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрийг сайжруулан ахисан түвшин болгох шаардлага үүссэн. Ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн хэрэглээний программын ялангуяа ахисан түвшний Excel чадвартай мэргэжилтэн бэлтгэхийн тулд компьютерийн хэрэглээ хичээлийнхээ хөтөлбөрийн агуулгад нь ахисан түвшний мэдлэгийн багтаасан сэдвүүдийг оруулах шаардлага тулгарч байна. Гэтэл энэхүү ахисан түвшний хөтөлбөрийг судлах оюутнуудын хувьд компьютерийн хэрэглээний програмын суурь мэдлэг, чадвар тааруу байдаг учраас хөтөлбөрийн хэрэгжилт хангалттай түвшинд хүрч чадахгүй асуудал үүсч байна. Энэ асуудлыг шийдэх арга замыг олох үүднээс энэхүү судалгааг хийх үндэслэл тавигдсан.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрийг судлан үзэж буй оюутнуудын хэрэглээний программын мэдлэг, чадвар болон хөтөлбөрт үнэлгээ хийх. Үүнд:

- Бүрэн дунд боловсролын мэдээлэл технологийн хичээлийн хөтөлбөрт программын мэдлэг хэр олгогдож байгааг тандах судалгаа хийх
- ЕБС төгсөгчдийн хэрэглээний программын мэдлэг хэр байгааг үнэлэх, өөрийн үнэлгээ хийлгэх
- Компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөр болон ахиц дэвшлийн судалгаа
- Дүгнэлт, санал

Судалгааны ач холбогдол

Судалгааны хэсэг

Оюутнуудын компьютерийн хэрэглээний программын мэдлэг чадварын үнэлгээ судалгааг дараах бичил судалгаануудыг ашиглан дүн шинжилгээ хийв.

1. Бүрэн дунд боловсролын мэдээлэл технологийн хичээлийн хөтөлбөрт программын мэдлэг хэр олгогдож байгааг тандах судалгаа хийх

Компьютерийн хэрэглээ хичээлийг 1-р түвшний оюутнууд 3 кр судалдаг ба одоогийн хөтөлбөр нь Microsoft office программ болох Word, Excel, Power Point программ, судалгааны үр дүн боловсруулах SPSS, Eviews програмуудын анхан шатны мэдлэг олгох зорилгоор орж байна. Хичээлийн хөтөлбөрөө шинэчлэхэд оюутнуудын суурь мэдлэг чухал бөгөөд бүрэн дунд боловсролын сургуульд үзсэн сэдвүүдийг матрицлан гаргалаа.

Хүснэгт 1. БДБ-ын мэдээллийн технологийн хичээлүүдийн матриц

№	Хичээлийн хөтөлбөрийн агуулга	Мэдээллийн технологи хичээл						
		Дунд анги				Ахлах анги		
		6-р анги	7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1	Мэдээлэл технологийн үндсэн ойлголт	-Мэдээллийн талаар, -Компьютерийн талаар үндсэн ойлголт	-Мэдээлэлтэй ажиллах, хэмжих -Компьютерт мэдээлэл, файльтай ажиллах	-Мэдээлэл, загвар байгуулах -Програм ба техник хангамжтай ажиллах -Алгоритм, үйлдлийн дараалал				
2	Мэдээлэл боловсруулах технологийн хэрэглээ	-Бичвэр мэдээлэл боловсруулах -Зурагтай ажиллах -Интернэтийн үндсэн ойлголт	-Баримт бичиг боловсруулах технологи /Word/ -Зураг зурах, засварлах -Танилцуулга боловсруулах технологи /PowerPoint/ -Цахим харилцаа, хэргийн цахим технологийн хичээлүүд	- Баримт бичиг, объектоор ажиллах -Зураг зөвхөн засварлах -Танилцуулга бэлтгэх, загвар -Хүснэгтэн мэдээлэл боловсруулах технологи -Нийлмийн сүлжээ, мэдээллийн хамтран эзэмшиж	- Баримт бичигт гаднаас объектууд нэмж оруулах -Зургийн дүрслэл, эффект -Хүснэгтэн мэдээлэлтэй ажиллах, тооцоолол хийж, график -Интернет, хайтын систем			
3	Мэдээлэл харилцаа холбооны технологи				-МООХТ-ийн үндсэн ойлголт -Компьютерийн сүлжээ -Алгоритм блок схем	-МООХТ-ийн зүйл, эрх зүй, аюулгүй ажиллагаа, онооны өмч		-МООХТ-ийн хөгжлийн чиг хандлага -Давшилтат технологийн хөгжил, хэрэглээ
4	Мэдээллийн нэгдсэн боловсруулалт					-Багц буюу нэгдсэн мэдээлэл боловсруулах,		
5	Мультимедиа					-Мультимедиа технологи - зурган, аудио, видео мэдээлэл боловсруулах	-Веб технологи -HTML хэл, хэрэглээ	
6	Өгөгдлийн сан					-Өгөгдлийн сангийн үндэс -Өгөгдлийн сан удирдах систем -Өгөгдлийн сангай ажиллах		
7	Компьютерийн системийн үндэс						-Техник хангамж -Програм хангамж	-Компьютерийн системийн хөгжлийн үндэс -Компьютерийн сүлжээ, интернет
8	Програмчлалын үндэс						-Мэдээлэл зүйн бодлого -Өгөгдөл ба хувьсагч -Давгал	-Бодлого бодох -Массив -Тандарт мөр -Мультимедиа програмчлал
9	Мэдээллийн систем							-Мэдээллийн системийн үндэс, төрөл -МС системийн хэрэглээ, хөгжүүлэлт


Дээрх матрицаас харахад хэрэглээний программыг 6-9-р ангиудад үздэг ба ахлах ангиудад компьютерийн системийн үндэс, програмчлалын үндэс, мэдээллийн системийн мэдлэгүүдийг түлхүү олгосон байна.

2. ЕБС төгсөгчдийн хэрэглээний программын мэдлэг хэр байгааг үнэлэх, өөрийн үнэлгээ хийлгэх

Мандах ИС-д элсэн орсон нийт 157 оюутанаас судалгаа авсан бөгөөд эдгээр оюутнуудын 100 оюутан нь Улаанбаатар хотын ЕБС, 20 оюутан нь аймгийн төвийн ЕБС, 37 оюутан нь сумын ЕБС-ийг тус тус төгссөн байсан.

Эдгээр оюутнуудаас оффис программын мэдлэг, хэрхэн хэрэглэж буй талаарх судалгааг авч статистик боловсруулалт хийлээ. Оффис программын мэдлэгийг 20 оноогоор дүгнэж графикийг гаргахад

Зураг 1. Элсэгчдийн оффисийн программын мэдлэгийн түвшингийн гистограмм



Дундаж оноо 8.1, стандарт хазайлт нь 3.7, нормал тархалттай байна. Энэ нь элсэгчдийн оффисийн программын мэдлэгийн түвшин харилцан адилгүй. Дундаж үнэлгээний төлөөлөх чадвар муу байгааг харуулж байна.

Мөн оффисын хэрэглээний программын мэдлэг ямар хэмжээнд байгааг ЕБС-ийн төгсөгчдөөс өөрсдөөр нь үнэлүүлсэн үр дүнг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Үнэлгээний түвшин

Программ	Үнэлгээний түвшин /хувиар/		
	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй
Word	12.7	42.0	45.3
Excel	6.5	28.6	64.9

Суралцагчдийн өөрийгөө үнэлсэн байдлаас харахад хангалтгүй буюу word программын мэдлэг муу гэж хариулсан нь 45.3%, excel программын мэдлэг муу гэж хариулсан нь 64.9% байна. Энэ нь оффисийн хэрэглээний программын мэдлэг хангалтгүй байгааг илтгэж байна.

Хүснэгт 3. Хи-квадрат тестээр үнэлсэн үнэлгээ

	Value	df	Asymptotic Significance (2-sided)
Pearson Chi-Square	11.113 ^a	10	.349
Likelihood Ratio	8.982	10	.534
Linear-by-Linear Association	.001	1	.977
N of Valid Cases	157		


Хи-квадрат тестийн аргаар үнэлж үзэхэд хөдөө сум, аймаг, улаанбаатар хотын ЕБС-д суралцаж төгссөнөөс үл хамааран дээрх программуудын мэдлэгийн түвшин ялгаагүй, хангалтгүй түвшинд байгаа нь нотлогдож байна. Энэ нь ЕБС-д ахлах ангид Microsoft office программ үздэггүйтэй холбоотой байна.

Мэдээллийн технологийн хичээлийн орчин нөхцөл, тулгамддаг асуудлын талаар суралцагчдаас асуулга авч дүгнэлээ.

Судалгаанд хамрагдсан суралцагчид мэдээллийн технологи хичээлийг 1-8 жил судалсан гэсэн хариулт өгсөн ба дундаж судалсан жил нь 5 жил байна.

Танай сургуульд компьютерийн лаборатори байгаа юу гэсэн асуултанд 139 суралцагч байгаа, 18 суралцагч байхгүй гэж хариулсан ба хот, аймаг, сумуудаар нь авч үзвэл:

Зураг 2. Комьпютерийн лабораторийн судалгаа



Судалгаанд хамрагдсан суралцагчид мэдээллийн технологи хичээлийг 1-8 жил судалсан гэсэн хариулт өгсөн ба дундаж нь 5 жил судалсан байна.

3. Компьютерийн хэрэглээ хичээлийн хэрэгжилт, сургалтын үйл ажиллагааны талаарх судалгаа

Одоо хэрэгжиж буй хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийхийн тулд Бүтэц дээр суурилсан үнэлгээний SURE загварыг ашигласан. Бүтэц дээр суурилсан үнэлгээний SURE загвар нь цуларсан өгөгдлийг боловсруулах бөгөөд үнэлгээний гол үндэс болсон зорилгыг логик бүтцийн дагуу зохих математик аргачлалаар тооцоолдог. Энэхүү математик аргачлалыг боловсруулсан эх суурь нь үнэлгээний зорилгын бүтэц юм.

Үнэлгээний үндсэн зорилго болох цуваа бүтэц, дэд зорилго болох зэрэгцээ бүтцүүдийг математикийн суурь онолууд болох, сигма алгебр, олонлогийн онол болон үржвэрийн орон зайн дүрэм, теоремоор батлан математик аргачлалыг боловсруулсан. (Т.Уранчимэг, Цахим сургалтын бүтцэд чиглэсэн үнэлгээний загвар, 2014) Энэхүү шинжлэх ухааны үндэслэлтэй загварыг сонгон ашиглав.


Sure загвараар үнэлсэн байдал:

Хөтөлбөрийг үнэлэх үндсэн (зорилго) задлан дэд зорилгуудыг тодорхойлсон.

Хүснэгт 3. Тодорхойлсон зорилтууд

	Тодорхойлсон зорилгууд	Дэд зорилгууд
В-1	Тухайн хичээлийн агуулга эзэмшсэн байдал	A11, A12, A13, A14, A15, A16, A17 A18, A19, A110
В-2	Тухайн хичээлийг судалсанаар дараах чадваруудыг эзэмшсэн	A21, A22, A23, A24, A25, A26

Дэд зорилгын логик бүтцийг зураг-1-т харуулав



Sure үнэлгээний загвар нь 4 төрлийн үнэлгээг гаргадаг давуу талтай.

Үүнд: Үнэлгээний үндсэн зорилго, дэд зорилгын үнэлгээ, үнэлгээнд оролцогч тус бүрийн үнэлгээ орно.

Хөтөлбөрийн үнэлгээг 2 үндсэн, 16 дэд асуулгын хүрээнд 0-3 онооны системээр үнэлсэн ба нийт 169 оюутныг хамарсан болно.

k	B ₁										B ₂						Q* _{e,k} (C)
	A ₁₁	A ₁₂	A ₁₃	A ₁₄	A ₁₅	A ₁₆	A ₁₇	A ₁₈	A ₁₉	A ₁₁₀	A ₂₁	A ₂₂	A ₂₃	A ₂₄	A ₂₅	A ₂₆	
1	0.67	1	0.33	1	1	1	0.67	0.67	0.67	0.67	1	1	1	1	1	1	1
2	1	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1
3	1	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
4	1	1	0.33	1	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	1
165	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
166	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1
167	1	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
168	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
169	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Q*(A _{ij})	0.92	0.89	0.75	0.92	0.93	0.91	0.87	0.9	0.92	0.91	0.9	0.92	0.93	0.91	0.92	0.91	Q*(C) = 0.9781
Q*(B _i)	0.99										0.97						

Sure загвар нь үр дүнг тооцоолоод үнэлгээний эрэмбийг оноо болон өнгөөр ялгаж харуулдаг бөгөөд өнгө тус бүр нь дараах үнэлгээг илэрхийлнэ.

Empirical evaluation score $Q_e^*(C)$

$$Q_e^*(C) = 0.978100$$

Компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрийг үнэлэхэд 2022-2023 оны хичээлийн жилийн 1-р улиралд компьютерийн хэрэглээ хичээлийг судалсан 1-р курсын НББ-Аудит, НББ-Татвар, НББ-Англи хэл, Банк менежмент, НББ-Эрх зүй, НББ-Мэдээллийн систем, механик инженерчлэл, Санхүүгийн менежмент, бизнесийн удирдлага ангиудаас 169 оюутан оролцож үнэлсэн ба үнэлгээ 0,9781 гарсан нь одоо хэрэгжиж буй хөтөлбөр 97,81% байгааг илэрхийлж байна. Эдгээр асуулгуудыг харахад хамгийн бага үнэлгээтэй асуулга нь Тухайн хичээлийн агуулга нь миний өмнө судалсан 10 жилийн "Мэдээллийн технологи" хичээлийн агуулгатай адилхан давтагдаж байсан уу гэсэн асуулт байсан.

Asymptotic confidence intervals $[q_{e,0}^*, q_{e,1}^*]$ for $Q_e(C)$ at confidence level $1 - \alpha = 0.90, 0.95, 0.99$ and sample standard deviation σ_e^* with $\sigma_e^* = \sqrt{\frac{1}{n-1} \sum_{k=1}^n (Q_{e,k}^*(C) - Q_e^*(C))^2}$.

$1 - \alpha$	$q_{e,0}^*$	$Q_e^*(C)$	$q_{e,1}^*$	σ_e^*
0.90	0.9688	0.9781	0.9874	0.0738
0.95	0.967		0.9892	
0.99	0.9635		0.9927	

Sample size $n = 169$

Зураг 4. Түүврийн итгэх интервалын үнэлгээ


Түүврийн хэмжээ 169, итгэх түвшинг 0.9, 0.95, 0.99 гэсэн 3 түвшинд сонгож итгэх интервалыг тогтоож үзэхэд стандарт хазайлт 0.0738 нь хэлбэлзэл бага асуулгууд боломжийн байгааг харуулж байна.

1-р курсын оюутнуудаас компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрийн судалгааг авахдаа нэмэлтээр “Word, Excel, PowerPoint хэрэглээний програмуудыг компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрт тусган орох нь хэр ач холбогдолтой, хэрэгтэй байсан бэ?”, “Компьютерийн хэрэглээ хичээлийг судалснаар хэрэглээний програм дээр ажиллах мэдлэг чадвар тань аль хэр нэмэгдсэн гэж үзэж байна вэ?”, “Компьютерийн хэрэглээ хичээлээс гадна "Ахисан түвшний Excel" гэсэн хичээл орох хэрэгцээ шаардлага байна уу?” гэсэн асуулгуудаар авсан.


Word, Excel, PowerPoint хэрэглээний програмуудыг компьютерийн хэрэглээ хичээлээр орох нь аль хэр ач холбогдолтой, өөрт тань хэрэгтэй байсан бэ?



Компьютерийн хэрэглээ хичээлийг судалснаар хэрэглээний програм дээр ажиллах мэдлэг чадвар хэр нэмэгдсэн гэж үзэж байна вэ?




Компьютерийн хэрэглээ хичээлээс гадна "Ахисан түвшний Excel" гэсэн хичээл орох хэрэгцээ шаардлага байна уу?




Судалгааны үр дүнгээс харахад оюутнууд Excel програмтай илүү сайн ажиллаж сурах, цагийг нэмэгдүүлэх, илүү ахисан түвшинд нэмж судлах сонирхол ихтэй байна. Нийт 1-р курсын оюутнуудаас Excel програмтай өмнө нь ажиллаж байсан уу гэсэн асуулганд 1 хэсгийн 24 хүүхдээс 1-3 хүүхэд л ажиллаж байсан гэсэн хариултыг өгсөн нь цаашид энэ програмтай ажиллах цагийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаагийн илрэл юм. Энэ нь оюутнууд ЕБС-д компьютерийн хэрэглээний програмуудыг ихэнх хувь нь судлаагүйтэй холбоотой бөгөөд ялангуяа MS-Excel програмтай ажиллаж үзээгүй оюутнууд ихэнх буюу 90 хувь байсан.

Мөн 1-р курсын 203 оюутнаас эхний хичээл дээр Word програм дээр ажиллах мэдлэг чадварыг 45 минутанд 1 нүүр олон янзын форматтай ажил хийлгэж чадварыг нь шалгасан. Энэ шалгалтаар оюутнууд Word програм дээр өгөгдсөн ажлыг хугацаандаа 39,4% нь хийж дууссан боловч текстийг форматлах, параграф тохируулах, стандарт албан бичгийн стандартын талаар ойлголт муу байгаа нь харагдсан. Мөн ахлах ангидаа word програм үзээгүй ер нь ажилладаггүй, текстийн форматлах, параграфын талаар ойлголтгүй гэдэг нь харагдаж байсан бөгөөд 14,8% нь бичих чадвар маш муу үсгээ хайсан байдалтай өгөгдсөн ажлаа хийж чадаагүй байна.


Оюутнуудын хэрэглээний програм дээр
ажиллах чадварын үнэлгээ хичээлийн эхэнд



Оюутнуудын хэрэглээний програм дээр ажиллах чадварын үнэлгээ
хичээлийн төгсгөлд



Оюутнуудын хэрэглээний програм дээр
ажиллах чадварыг хичээлийн эхэнд болон
төгсгөлд харьцуулсан үнэлгээ



4. Компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөр болон ахиц дэвшлийн судалгаа

Үнэлэмжийн тоон өгөгдлийн тойм	Элсэн орох үеийн шалгалт - inbound		Төгсөн гарах үеийн шалгалт - outbound	
	Шалгалтын оноо	Гүйцэтгэлийн хувь	Шалгалтын оноо	Гүйцэтгэлийн хувь
Туршилтын тоо	177		173	
Дундаж оноо	11	44%	13	52%
Стандарт хазайлт	2.89		3.43	
Вариацийн коэффициент	8.36	33.4%	11.75	47%
Хамгийн бага оноо	2	8%	5	20%
Хамгийн өндөр оноо	20	80%	21	84%
Медиан оноо	11	44%	13	52%
Хамгийн олон тохиолдох оноо	12	48%	11	44%

Компьютерийн хэрэглээ хичээлийн outbound-ын шалгалтын дундаж үнэлгээ нь 52%-ийн гүйцэтгэлтэй буюу оюутны чадварын харьцангуй үнэлгээгээр дундаж гэсэн ангилалд багтсан байна. Шалгуулагчдын тэн хагас нь үнэлгээний гүйцэтгэлийн 52% буюу дундаж үнэлгээ авсан бол үлдсэн хагас нь дунджаас доогуур үнэлгээ авчээ. Хичээл дуусах үеийн шалгалтын дундаж үнэлгээ өсөж, стандарт хазайлт 3.43 оноо болж өссөн боловч хэлбэлзэл дунд зэргийн байгаа нь онооны тархалт хэвийн бус буюу оюутнууд жигд мэдлэг эзэмших тал дээр хангалтгүй байгааг илтгэж байна. Эндээс дүгнэхэд хамгийг бага оноо болон дундаж үнэлгээ дээшилсэн байна. Энэ нь Компьютерийн хэрэглээ хичээлийн суурь мэдлэг дээшилсэн үр дүнтэй байна.

ДҮГНЭЛТ

1. MS- Office программыг ахисан түвшинд заахын тулд суурь мэдлэг чухал тул ЕБС-ын мэдээллийн технологи хичээлийн хөтөлбөрт Microsoft office программ хэрхэн тусгагдсаныг матрицлан авч үзэхэд агуулга дунд ангиудад ордог, ахлах ангиудад ордоггүй байна. ЕБС-ын төгсөгчдөөс мэдлэгийг нь тестээр шалгаж үзэхэд Microsoft office программын мэдлэг дундаас доогуур тааруухан байгаа нь тодорхойлогдсон ба өөрсдөөр нь үнэлүүлэхэд мөн л хангалтгүй гэж үнэлсэн байна. Энэ нь их дээд сургуульд элсэн ороод шууд ахисан түвшиний программ үзэх боломжгүй харуулж байна.
2. Дараагийн нэг зорилго нь одоо заагдаж буй Компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрөө үнэлсэн ба хэрэгжиж буй хөтөлбөр 97.81% үнэлэгдсэн нь судалж буй оюутнууд хөтөлбөрийн хэрэгжилт сайн гэж үнэлжээ. Word, Excel, PowerPoint хэрэглээний програмуудыг компьютерийн хэрэглээ хичээлийн хөтөлбөрт тусган орох нь хэр ач холбогдолтой, хэрэгтэй байсан бэ? Гэсэн асуултанд маш хэрэгтэй гэж судалгаанд оролцсон оюутнуудын 74.0% нь, компьютерийн хэрэглээ хичээлийг судалснаар хэрэглээний програм дээр ажиллах мэдлэг чадвар хэр нэмэгдсэн вэ? Гэсэн асуултанд 87.5% маш их, их гэж хариулсан бол Компьютерийн хэрэглээ хичээлээс гадна Ахисан түвшний Excel гэсэн хичээл орох хэрэгцээ шаардлага байна уу? Гэсэн асуултанд 90.5% нь маш их байна гэж хариулжээ.

3. Энэхүү судалгаанаас хархад ЕБС төгсөгчидийг бид оффисын ажилтан болгож албан бичиг баримтыг стандартын дагуу боловсруулах мэдлэг чадвартай болгон бэлтгэн гаргахад Microsoft office программ үзэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд сургалтын хөтөлбөртөө

Microsoft office программын ахисан шатны Excel хичээлийг багтаахаар кредит цагийг нэмэх шаардлагатайг харуулж байна.

4. Их дээд сургуульд ахисан түвшний MS-Office хэрэглээний програм орохын тулд ЕБС-ийн мэдээллийн технологи хичээлийн хөтөлбөрийн агуулгыг өөрчлөн ахлах ангиудад MS-Office програмыг орох шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Бадарч, Д (2021) Дээд боловсролын онол, арга зүй парадигмын шилжилт, багшлахуй, суралцахуй. УБ
2. Баярцэцэг.Г, Энхболд.А. (2017). “Иргэдийн мэдээллийн технологийн чадварыг нэмэгдүүлэх нэгэн боломж” Цэцэрлэг хот
3. Ичинхорлоо,Ш, (2011), Сургалтын арга зүйн шинэчлэл, УБ
4. Ичинхорлоо,Ш, (2012), Сурах арга зүй, УБ
5. Ичинхорлоо,Ш, (2012), Сургалтын онол, хэрэглээ, УБ
6. Ичинхорлоо,Ш, (2012), Дээд сургуулийн сургалт: онол, арга зүй, УБ
7. Мядагмаа.Р, Ариунболор.Д (2017), Сургалтын явцын үнэлгээг шинэчлэн сайжруулах, сургалтын хөтөлбөрт нэгдсэн үнэлгээ хийх арга зүйн зөвлөмж, УБ
8. Орхон. (2016). Дээд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах нь: Сургалтын үйл явц, шалгалт үнэлгээг суралцахуйн зорилтот үр дүнтэй уялдуулах нь. УБ .
9. Цэдэвсүрэн.Д. (2021). Бүрэн дунд боловсролын мэдээллийн технологийн хөтөлбөрийн хэрэгжилтэнл тулгарч буй асуудлын судалгаа . Улаанбаатар
10. Цэдэвсүрэн.Д, У. (2020). Бүрэн дунд болон дээд боловсролын мэдээллийн технологи хөтөлбөрийн агуулгын харьцуулалт. Улаанбаатар.
11. Эрдэнэхүү. Н, (2019). Үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөрт үнэлгээ хийх жишиг арга зүй. Retrieved 9 2021, from
12. Дээд боловсрол судлалын монголын нийгэмлэг. “Дээд боловсролын шинэчлэл- сургалтын технологи” хэлэлцүүлгийн илтгэлүүд. (2013), УБ
13. Микалела Мартин. “Чанарын дотоод баталгаажуулалт” (2019), УБ
14. Ж.Төгсөө, Т.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа. “Танхим болон цахим хосолсон сургалтын онол, арга зүйн зарим асуудал /Мандах их сургуулийн жишээн дээр/, (2020) УБ
15. Танхим-Цахим хосолсон сургалтын ялгаа, чиг хандлага, Зайн сургалтын нийтлэг болон онцгой шинж” итгэл (2019)

MOBILE APP ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ТЕХНОЛОГИУД ТҮҮНИЙ ЯЛГАА, АСУУДЛУУД /FLUTTER ПРОГРАМЧЛАЛ/

Х.Сувд-Эрдэнэ¹

Мандах Их Сургууль-Мэдээлэл, Технологийн Сургууль

Е-майл: suvderdene@mandakh.edu.mn¹

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажилдаа мобайл хөгжүүлэлтийн өнөөгийн байдал, технологиудын ялгаа, ашиглалтын асуудлууд, олон улсын жишигт анализ хийж ажиллаа. Мобайл аппликейшн хөгжүүлэлт нь тус бүр өөрийн давуу тал, сул тал, хэрэглээний тохиолдол бүхий төрөл бүрийн технологиудыг хамардаг. Flutter бол платформ хоорондын гар утасны програмуудыг хөгжүүлэх түгээмэл ашиглагддаг технологи юм. Flutter түүний бусад технологиос ялгарах онцлог, гар утасны программ хөгжүүлэхтэй холбоотой нийтлэг асуудлуудыг судаллаа.

Түлхүүр үг: Мобайл, хөгжүүлэлт, мэдээллийн систем, програмчлалын технологи

MOBILE APP DEVELOPMENT TECHNOLOGIES, THEIR DIFFERENCES AND PROBLEMS

/FLUTTER PROGRAMMING/

Kh.Suvd-Erdene¹

Mandakh University – Information technology school

Email – suvderdene@mandakh.edu.mn¹

In this research, I analyzed the current state of mobile development, technology differences, usage issues, and international benchmarks. Mobile app development involves various technologies, each with its own strengths, weaknesses, and use cases. Flutter is a popular framework for developing cross-platform mobile applications. Let's explore Flutter, its differences from other technologies, and some common problems associated with mobile app development.

Keywords: Mobile, development, information systems, programming technologies

ОРШИЛ

Судалгааны сэдэв сонгосон үндэслэл: Мобайл аппликейшн хөгжүүлэлт нь тус бүр өөрийн онцлог, давуу тал, сорилттой олон төрлийн технологиудыг хамардаг. Иймд гар утасны программ хөгжүүлэх зарим алдартай технологиудыг тоймлон, тэдгээрийн ялгааг онцолж, хөгжүүлэх үйл явцтай холбоотой нийтлэг бэрхшээлүүдийн талаар судлаж, хамгийн тохиромжтой технологийг сонгоходоо хөгжлийн хурд, гүйцэтгэл, тогтвортой байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж энэхүү сэдвийг сонголоо.

Судалгааны ажлын зорилго: Гар утасны программ хөгжүүлэх хэд хэдэн технологи түгээмэл болсон. Үүнээс дурдвал Flutter, react native, swift, хamarin, ios, java зэрэг технолгиуд байна. Эдгээр технологиуд нь хэрэглэхэд хялбар, хөгжүүлэгчдийн олон нийтийн дэмжлэг, гүйцэтгэл, платформ хоорондын чадвар зэрэг янз бүрийн шалтгааны улмаас түгээмэл байдаг. Технологийн сонголт нь ихэвчлэн төслийн шаардлага, хөгжүүлэлтийн багийн туршлага болон бусад хүчин зүйлээс хамаардаг. Зөв технологийг сонгох нь төслийн шаардлага, хөгжүүлэлтийн багийн туршлага, зорилтот хэрэглэгчдээс хамаардаг, хамгийн тохиромжтой мэдээллийн системийн боломжийг эрэлхийлж санал боловсруулах нь энэхүү судалгааны ажлын зорилго болно.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах **зорилтуудыг дэвшүүлэн** судаллаа.

1. Гар утасны технологийн шинэчлэлийг судлах
2. Олон улсын мобайл хөгжүүлэлтийн чиг хандлага, UI шийдлүүд
3. Мобайл хөгжүүлэх түгээмэл технологиудын ялгаатай талууд
4. UI framework-уудын асуудлууд, гадаадын зарим улс орнуудын сайн жишиг, UI судлах

Судлагдсан байдал: Энэхүү судалгааны ажилд ажиглалт хийх, харьцуулах технологийн асуудлыг харьцуулан судалсан.

Судалгааны ач холбогдол: Судалгааны ач холбогдол нь хүмүүст мобайл аппликейшн хийхэд тулгамдаж буй асуудал түүнийгээ хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлсны үндсэн дээр зөв технологийг сонгоходд оршино.

1. FLUTTER FRAMEWORK

Flutter нь гар утас, вэб болон ширээний компьютерт зориулсан хөрвүүлсэн програмуудыг нэг кодын баазаас бүтээх зорилгоор Google-ээс бүтээсэн нээлттэй эхийн UI програм хангамж хөгжүүлэх хэрэгсэл юм. 2017 онд гарсан Flutter нь өндөр хүчин чадалтай, үзэмж сайтай, платформ хоорондын програмуудыг хөгжүүлэхэд чиглэгдсэнээрээ алдартай болсон.

Flutter-ийн үндсэн шинж чанарууд:

✓ Single Codebase /Нэг кодын сан

- Flutter нь хөгжүүлэгчдэд нэг удаа код бичиж, iOS, Android, вэб, ширээний компьютер зэрэг олон платформ дээр байрлуулах боломжийг олгодог. Энэ арга нь хөгжүүлэлтийн хугацаа болон засвар үйлчилгээний хүчин чармайлтыг багасгадаг.

Programming language /Програмчлалын хэл/

- Flutter програмчлалын хэлээр Dart-ийг ашигладаг. Dart бол Google-ийн боловсруулсан орчин үеийн, объект хандалтат хэл юм. Dart нь бусад хэл шиг тийм ч алдартай биш байж болох ч сурахад хялбар байхаар бүтээгдсэн бөгөөд үр ашигтай, гүйцэтгэлтэй програмуудыг бүтээхэд тохиромжтой функцуудыг санал болгодог.

Hot reload /Дахин ачааллах/

- Flutter онцлох шинж чанаруудын нэг нь "Hot reload" бөгөөд энэ нь хөгжүүлэгчдэд програмыг бүхэлд нь дахин эхлүүлэхгүйгээр хөгжүүлэлтийн явцад кодын өөрчлөлтийн шууд нөлөөллийг харах боломжийг олгодог. Энэ нь хурдацтай хөгжиж, туршилт хийхэд тусалдаг.

Widget-үүдийн багц

- Flutter нь хэрэглэгчийн нарийн төвөгтэй интерфэйсийг бий болгоход зориулагдсан тохируулж болох виджетүүдийн иж бүрэн багцыг өгдөг. Эдгээр виджетүүд нь реактив тогтолцоог дагадаг бөгөөд олон талт зохион байгуулалт, дизайныг бий болгохын тулд нэгтгэж болно.

High performance /Маш сайн гүйцэтгэл

- Flutter програмуудыг уугуул ARM кодоор хөрвүүлснээр өндөр гүйцэтгэлтэй, жигд хөдөлгөөнт дүрсүүд бий болно. Энэ нь Flutter-ээр боловсруулсан програмууд нь янз бүрийн төхөөрөмжүүдийн гүйцэтгэлийн хүлээлтийг хангадаг болохыг баталгаажуулдаг.

Platform integration

Flutter нь төрөлх функцууд болон API-уудтай саадгүй нэгтгэх боломжийг олгодог залгаасууд болон багцуудыг хангадаг бөгөөд хөгжүүлэгчдэд камер, мэдрэгч гэх мэт төхөөрөмжийн онцлог шинж чанаруудыг ашиглах боломжийг олгодог.

1. Open source-Нээлттэй Нээлттэй эхийн төсөл болох Flutter нь хөгжүүлэгчдэд түүний хөгжилд хувь нэмрээ оруулах, хүрээг өөрчлөх, кодын баазын ил тод байдлыг ашиглах боломжийг олгодог.

Google-н дэмжлэгтэй фреймворкийн хувьд Flutter нь тогтмол шинэчлэлт, сайжруулалт, байнгын дэмжлэг авдаг.

Flutter нь янз бүрийн салбарт алдартай болсон бөгөөд олон хөгжүүлэгчид түүний

хөгжүүлэлтийн процессыг оновчтой болгох, хэрэглэгчийн байнгын туршлагыг хангах, өөр өөр платформ дээр өндөр гүйцэтгэлтэй програмуудыг хүргэх чадварыг үнэлдэг. Энэхүү framework нь шинэ боломжууд болон сайжруулалтуудаар үргэлжлэн хөгжиж байгаа нь платформ хоорондын програм хөгжүүлэх сонирхол татахуйц сонголт болж байна.

2. МОБАЙЛ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ТЕХНОЛОГИУД ТҮҮНИЙ ЯЛГААТАЙ ТАЛ

React native:

Хэрэглээ: React Native нь өргөн, идэвхтэй нийгэмлэг бүхий салбарт өргөн хэрэглэгдэж ирсэн. Facebook, Instagram, Uber Eats, Airbnb зэрэг олон алдартай компаниуд React Native программыг гар утасны программдаа ашигласан.¹

Шалтгаан: React Native-ийн алдар нэр нь олон хөгжүүлэгчдэд танил болсон JavaScript хэл, мөн гүйцэтгэл, чадвараас шалтгаалдаг.

Flutter

Хэрэглээ: Flutter нь ихээхэн анхаарал татаж, Google Ads, Alibaba, Tencent, Reflectly зэрэг компаниудад ашиглагдаж байна.

Flutter-ийн сонирхол татахуйц тал нь олон платформд зориулсан ганц кодын бааз, дахин ачаалах функц, илэрхий UI, хүчирхэг гүйцэтгэлд оршдог². Энэ нь ихэвчлэн харагдахуйц, тогтвортой UI үүсгэх чадвараараа сонгогддог.

Swift, Kotlin/Java

Хэрэглээ: Олон компаниуд, ялангуяа платформын онцлог шинж чанар, гүйцэтгэлд онцгой анхаарал хандуулдаг компаниуд iOS-д зориулсан³ Swift, Android-д зориулсан Kotlin эсвэл Java-г ашиглан native хөгжүүлэлтийг сонгосоор байна.

Native хөгжүүлэлт нь платформд зориулсан API-д шууд хандах, оновчтой гүйцэтгэл, платформ бүрийн хамгийн сүүлийн үеийн боломжуудыг ашиглах боломжийг олгодог.

Xamarin

Хэрэглээ: Майкрософт компанийн эзэмшдэг Xamarin-ийг Alaska Airlines, Honeywell, Olo зэрэг компаниуд ашигладаг. Xamarin нь C#-г ашиглах, одоо байгаа. NET ур чадвараа ашиглах чадвараараа сонгосон. Энэ нь платформ хоорондын хөгжүүлэлт болон native API-д хандах боломжийг олгодог.

Progressive Web Apps (PWAs):

Хэрэглээ: PWA-г Twitter, Forbes, Pinterest зэрэг компаниуд ашигладаг. PWA нь хөгжүүлэгчдэд native програм шиг ажиллах вэб програмуудыг үүсгэх боломжийг олгож, төхөөрөмжүүдийн хооронд саадгүй туршлагыг санал болгодог.

¹ <https://reactnative.dev/>

² Flutter.dev

³ Swift.com

3. МОБАЙЛ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ СУДАЛГАА

Технологи	Flutter	React native
Програмчлалын хэл	Dart Flutter нь Google-ийн бүтээсэн Dart хэлийг ашигладаг. Дарт бол объектод чиглэсэн бөгөөд энгийн бөгөөд сурахад хялбар гэдгээрээ алдартай	Javascript React Native нь өргөн хэрэглэгддэг, уян хатан байдгаараа алдартай JavaScript дээр тулгуурладаг.
Дахин ачаалалт	Flutter-ийн дахин ачаалах функц нь хөгжүүлэгчдэд кодын өөрчлөлтийн нөлөөг шууд харах боломжийг олгож ⁴ , хөгжүүлэлтийн процессыг хурдасгадаг.	React Native нь дахин ачааллыг дэмждэг бөгөөд энэ нь хөгжүүлэгчдэд програмыг бүрэн дахин эхлүүлэхгүйгээр бодит цагийн өөрчлөлтийг харах боломжийг олгодог. ⁵
UI	Flutter нь UI үүсгэх өөрийн тохируулж болох виджеттэй. ⁶ Эдгээр виджетүүд нь платформ дээр тогтвортой харагдах байдлыг хангаж өгдөг.	React Native нь эх бүрэлдэхүүн хэсгүүдийг ашигладаг бөгөөд энэ нь заримдаа илүү эх төрхийг бий болгодог. Гэсэн хэдий ч платформ дээр тогтвортой харагдах байдлыг бий болгохын тулд нэмэлт хүчин чармайлт шаардагдана.

Архитектур	Flutter нь реактив програмчлалын Загварыг ашигладаг бөгөөд UI нь Програмын төлөвийн Функц юм. Виджетийн Модыг төлөв өөрчлөгдөх үед дахин бүтээж, гунхагласан ⁷ , үр ашигтай UI дизайн хийх боломжийг олгодог.	React Native нь Flux Архитектур дээр суурилсан бөгөөд өгөгдөл нь програмаар нэг чиглэлтэй урсдаг ⁸ . Энэ нь тодорхой, урьдчилан таамаглах боломжтой төрийн удирдлагын тогтолцоог баталгаажуулдаг.
------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

⁴ "Flutter in Action" by Eric Windmill

⁵ "Learning React Native" by Bonnie Eisenman:

⁶ "Beginning App Development with Flutter: Create Cross-Platform Mobile Apps" by Marco L. Napoli

ДҮГНЭЛТ

JavaScript болон React-ийг аль хэдийн мэддэг хүмүүс болон мэдрэмжийг эрхэмлэдэг хүмүүст тохиромжтой. Том, тогтсон олон нийтийг шаарддаг төслүүдэд тохиромжтой. Дүгнэж хэлэхэд, Flutter болон React Native хоёулаа платформ хоорондын хөгжлийн төлөө хүчтэй өрсөлдөгчид бөгөөд тус бүр өөрийн давуу тал, анхаарах зүйлстэй. Тэдгээрийн хоорондох сонголт нь ихэвчлэн хөгжүүлэгчийн туршлага, төслийн шаардлага, хувийн сонголт зэрэг хүчин зүйлээс хамаардаг. Хөгжүүлэгчид өөрсдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох framework-г сонгохын өмнө эдгээр талыг сайтар үнэлэх хэрэгтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. "Google Flutter Mobile Development Quick Start Guide" by Packt Publishing
2. "React Native in Action" by Nader Dabit
3. "Flutter in Action" by Eric Windmill
4. "Learning React Native" by Bonnie Eisenman:
5. "Beginning App Development with Flutter: Create Cross-Platform Mobile Apps" by Marco L. Napoli
6. <https://reactnative.dev/>
7. [Flutter.dev](https://flutter.dev)
8. [Swift.com](https://swift.com)

⁷ "Google Flutter Mobile Development Quick Start Guide" by Packt Publishing

⁸ "React Native in Action" by Nader Dabi

ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СИСТЕМ ДЭХ СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙН ОРОЛЦОО

Цамбаасүрэн Цолмон^{1, a *}, Чулуунбат Төрбадрах^{2, b}

¹Инженер технологийн тэнхимийн багш

²turbadrakh@mandakh.edu.mn

^a tsolmon.ts@mandakh.edu.mn, ^b turbadrakh@mandakh.edu.mn,

* Цамбаасүрэн Цолмон

Хураангуй

Монгол улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 10340.1 сая кВт.ц болж өнгөрсөн оноос 5.46%-иар өссөн ба нийт үйлдвэрлэсэн цахилгааны 90.84%-ийг дулааны цахилгаан станцаар, 9.16% ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хангасан байна.¹ Уг онд 2161.5 сая кВт.ц цахилгааныг импортолсон нь өмнөх онтой харьцуулахад 299.6 сая кВт.ц буюу 13.9 %-иар өссөн байна. Монгол улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ өдөр ирэх тусам өсч шинэ эх үүсвэр дутмаг учир Импортын цахилгаан эрчим хүчний хэрэглээ мөн өсч байна.

2015-2030 онд баримтлах бодлогын хүрээнд Монгол улсын эрчим хүчний системийн нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний СЭХ эзлэх хувь хэмжээг 2023 онд 20%-д, 2030 онд 30%-д тус тус хүргэж нэмэгдүүлэх зорилт тавьсан байна.²

Мөн Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хүртэл хувиар бууруулах, 2030 он гэхэд эрчим хүчний хэрэглээний 30% -ийг СЭХ-ээр хангах, бүс нутгийн эрчим хүчний үйлдвэрлэлд хувь нэмэр оруулах зорилтыг дэвшүүлсэн.³ Иймд төвийн бүсийн нэгдсэн систем ТБНС-д сэргээгдэх эрчим хүчний СЭХ эр үүсвэрийн оролцоо хэр нөлөөлж ямар үүрэг гүйцэтгэж байгааг судлахыг зорилоо.

Түлхүүр үг: Сэргээгдэх эрчим хүч, үйлдвэрдэд, хэрэглээ, импорт

ОРШИЛ

Эрчим хүчний салбар нь Монгол Улсын үндэсний аюулгүй, бие даасан байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий хөгжлийн тэргүүлэх салбарын нэг. Монгол Улсын эрчим хүчний систем нь төвийн бүсийн нэгдсэн систем (ТБНС), баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС), Алтай-Улиастайн эрчим хүчний систем (АУЭХС), дорнод бүсийн эрчим хүчний систем (ДБЭХС), өмнөд бүсийн цахилгаан хангамж (ӨБЦТС) гэсэн таван хэсгээс бүрддэг.

¹ Эх үүсвэр: Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2022


² Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг 2015, УБ хот

³ “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого

Өнөөдрийн байдлаар дулааны 9 цахилгаан станц, Дөргөн, Тайширын усан цахилгаан станц, Алтай, Улиасгайн дизель станцууд болон бага, дунд чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс цахилгаан эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэж байгаа бол ОХУ, БНХАУ-аас импортоор худалдан авч 220 кВ, 110 кВ-ын дэд станц, дамжуулах сүлжээ, түгээх сүлжээгээр дамжуулан Монгол Улсын 330 гаруй сум, суурин газрын цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангаж байна⁴. Одоогийн байдлаар ТБНС нь нийт дамжуулах, түгээх 28187 км урт шугамтай. Үүнд 220 кВ-ын 1279 км, 110 кВ-ын 3491 км, 35кВ-ын 5714 км, 15-20 кВ-ын 1973 км, 6-10 кВ-ын 8506 км, 0.22-0.4 кВ-ын 7224 км шугамтай, системд нийт 4775 дэд станцууд ажиллаж 575168 хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангаж ажиллаж байна.⁵

Эрчим хүчний нэгдсэн системд одоогоор 3 салхин цахилгаан станц, 8 нарны цахилгаан станц, 7 усан цахилгаан станц тус тус эрчим хүч үйлдвэрлэж байна.

ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ (ТБНС)-ний дүнгээр 2022 онд 7,745.2 сая кВт. ц цахилгаан үйлдвэрлэж, 7.024.1 сая кВт.ц цахилгааныг түгээсэн нь өмнөх онтой харьцуулахад 407.2 сая кВт. ц буюу 6.1%-иар өссөн бол дулааны үйлдвэрлэл 10,414.1 мян. Гкал байгаа нь өмнөх оноос 697.8 мян. Гкал буюу 7.2%-иар осжээ.



Зураг 1. Монгол улсын эрчим хүчний систем

БАРУУН БҮСИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ (ББНС)-ний цахилгааны хэрэглээ 2022 онд 238.2 сая кВт.ц болж, өмнөх оноос 22.2 сая кВт.ц буюу 10.3%-иар өссөн ба нийт хэрэглээний 12.1%-ийг Дөргөний УЦС, 6.5%-ийг Ховд нар НЦС тус тус үйлдвэрлэж, 81.4%-ийг ОХУ болон БНХАУ-аас импортоор хангажээ.

ЗҮҮН БҮСИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ (ЗБНС)-ний цахилгааны хэрэглээ 2022 онд 4.0 сая кВт.ц буюу 1.4%-иар буурсан. Дорнодын дулааны цахилгаан станцын 2022 онд 242.7 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, 210,6 сая кВт.ц цахилгаан, 326.0 мян.Гкал дулаан

⁴ <https://online.fliphtml5.com/seigx/iivw/#p=1>

⁵ Эрчим хүчний статистик үзүүлэлт, тайлан

түгээсний 2021 онтой харьцуулахад цахилгаан 0.6%-иар буурсан, харин дулаан 0.9%-иар өссөн байна.

АЛТАЙ-УЛИАСТАЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ (АУНС)-ний цахилгааны хэрэглээ 2022 онд нийт 108.4 сая кВт.ц байгаа нь өмнөх оноос 9,1 сая кВт.ц буюу 9.2%-иар өссөн ба ТБНС-ээс 72.8 сая кВт.ц эрчим хүч худалдан авсан нь 3.1 сая кВт.ц буюу 4,5%-иар нэмэгдэж ББЭХС-ээс худалдан авсан орчим хүч 3.5 сая кВт.ц буюу өмнөх оны түвшинд гарсан бөгөөд сэргээгдэх эрчим хүчний үүсвэрүүд болон дизель станцын үйлдвэрлэл 32.1 сая кВт.ц болж, 6.1 сая кВт.ц буюу 23.2%-иар нэмэгдсэн байна.

1. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН АРГА ЗҮЙ

2022 оны байдлаар Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд Сэргээгдэх эрчим хүчний 11 эх үүсвэр үйл ажиллагаагаа явуулж байна. ТБНС-д 3 Салхин цахилгаан станц холбогдон нийт 155МВт суурилагдсан хүчин чадалтай, 6 Нарны цахилгаан станц холбогдсон, нийт 95 МВт суурилагдсан хүчин чадалтай, 2 Усан цахилгаан станц холбогдон, нийт 23 МВт суурилагдсан хүчин чадалтай байна.

Хүснэгт 1. Монгол улсад үйл ажиллагаагаа явуулдах СЭХ-ний эх үүсвэрүүд⁶

Д.д	Салхин цахилгаан станц	Суурилагдсан хүчин чадал
1	Салхит	50 МВт
2	Цэций	50МВт
3	Шанд салхин парк	55МВт
Нарны цахилгаан станц		
1	Дархан	10МВт
2	Моннаран	10МВт
3	Гэгээн	15МВт
4	Сүмбэр	15 МВт
5	Бөхөг	15 МВт
6	Говь	30 МВт
Усан цахилгаан станц		
1	Дөргөн	12 МВт
2	Тайшир	11 МВт
Нийт Суурилагдсан хүчин чадал		273 МВт


Монгол улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 10340.1 сая кВт.ц болж өнгөрсөн оноос 5.46%-иар өссөн ба нийт үйлдвэрлэсэн цахилгааны 90.84%-ийг дулааны цахилгаан станцаар, 9.16% ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хангасан байна.

⁶ National dispatching center 2023 page 16

Хүснэгт 2. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ / Сая кВт.ц /

Эх үүсвэр	2018	2019	2020	2021	2022
Дулааны цахилгаан станц	6152.4	6346.6	6493.6	7109.6	7428.5
Дизель цахилгаан станц	3.7	3.0	2.7	1.1	1.2
Нарны эх үүсгүүр	51.5	109.0	108.9	156.9	179.7
Усан цахилгаан станц	78.2	85.4	83.3	83.1	61.7
Салхин цахилгаан станц	339.0	459.3	457.2	563.0	508.5
Нийт үйлдвэрлэл	6624.8	7003.3	7145.7	7913.6	8178.6
Импрот	1683.6	1715.8	1705.6	1861.9	2161.5

Нийт хэрэглээний 79.1% буюу 8178.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн хэрэглэгчдээ хангасан бол 20.8% буюу 2161.5 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад 299.6 сая кВт.ц буюу 13.9 %-иар өссөн байна.




Зураг 2. Эх үүсвэрийн бүтэц ба импорт⁷

2022 онд 10340.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэсний 9.16% ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хангасан байна. Үүнд 23.9%-ийг нар, салхины эх үүсвэрээр, 67.9%-ийг усан цахилгаан станцаар, 8.2%-ийг дизель станцаар тус тус бүрдүүлсэн байна.


⁷ Эх үүсвэр: Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2022

2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН



Зураг 3. 2018-2022 оны эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг харууллаа

Дээрх зурагт 2018-2022 оны эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг харуулсан байна. Мөн Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр 2020 онд 649.4 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлсэн бол 2022 онд 749.9 сая кВт.цаг болж 100.5 сая кВт.цагаар нэмэгдсэн байна.



Зураг 4. 2018-2022 оны эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг хувиар харууллаа

Дээрх зурагт 2018-2022 оны эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг хувиар харуулсан байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд системд холбогдоогүй байх үед - 92.7%-ийг ДЦС-ууд, 7.3%-ийг импортоор Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд системд холбогдсоноор дотоодын түгээлтийн хэмжээ 92.7 – 96.9% хүртэл өсч, импортын эрчим

хүчээр хэрэглээний 3.1 – 7.3 %-ийг хангадаг болсон байна⁸. Эдгээр СЭХ-ний эх үүсвэрүүд ТБЭХС – холбогдсоноор 2022 оны байдлаар импортын цахилгаан эрчим хүчнийг 7.3% иар бууруулахад гол үүрэг гүйцэтгэсэн нь харагдаж байна.



Зураг 5. Нэгдсэн сүлжээний рхгил ачаалалд оролцсон байдал

2022 оны Нэгдсэн сүлжээний өвлийн их ачаалал 1469 МВт ба энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 101 МВт буюу 9.9 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Энэ өсөлт нь системийн томоохон хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн мөн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын хэрэглэгчдийн халаагуурыг цахилгаанаар халдаг төхөөрөмжөөр шийдсэнтэй холбоотой гэж үзэж байна. Оргил ачаалалд Шанд СЦС 3.6%, Цэций СЦС 3.3%, Салхит 2.5% ийн оролцоотой ажилласан байна.

Монгол улс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн тэр дундаа нар болон салхины баялаг нөөцтэй. Манай улсын анхны том чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох “Салхит”-ын салхин цахилгаан станц 49.6 МВт- хүчин чадалтайгаар, 120 сая ам долларын хөрөнгө оруулалтаар 2013 онд баригдсан бөгөөд 2017 онд Өмнөговь аймгийн Цэций салхин цахилгаан станц 55 МВт-ын хүчин чадалтайгаар, 2018 онд Сайншанд салхин цахилгаан станц 50 МВт-ын хүчин чадалтайгаар ашиглалтанд орж ТБНС-д холбогдон зэрэгцээ ажиллаж байна.

Манай улсын хувьд 2015 онд төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичгийг баталсан. Энэ баримт бичигт эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20%, 2030 онд 30%-д хүргэхээр тусгасан [1]. Өнөөдрийн байдлаар нэгдсэн сүлжээнд холбогдсон салхин цахилгаан станцын тоо 3 болсон бөгөөд эдгээрийн нийт суурилагдсан хүчин чадал 155 МВт хүрээд байна. Цаашдаа их чадлын салхин цахилгаан станцууд олноор бий болох нь тодорхой болж тусгай зөвшөөрөл авч судалгааны төвшинд явагдаж байгаа салхин эх үүсвэрийн суурилагдсан чадал 450 МВт орчим болсон ба 2025 он гэхэд СЦС-ын суурилагдсан чадал төвийн бүсийн нэгдсэн системийн суурилагдсан хүчин чадлын 30 хувьд хүрэх төсөл төлөвлөгөө байна.

⁸ Диспетчерийн зохицуулалт, горим төлөвлөлт 2021 он

Мөн 2022 онд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт 10 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай нарны цахилгаан станц, Завхан аймгийн Алдархаан сумын нутагт 5 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай нарны цахилгаан станц, Завхан аймгийн Улиастай сумын нутагт 0.6 МВт/3.6 МВт.ц суурилагдсан хүчин чадал бүхий эрчим хүчний хуримтлуурын систем тус тус барих тусгай зөвшөөрлийг олгосон. Үүний үр дүнд Алтай-Улиастайн эрчим хүчний системийн цахилгаан үйлдвэрлэлийн хэмжээ жилд 30.3 сая кВт.д-аар нэмэгдэх боломж бүрэлж байна.

Ховд аймгийн Мянгад сумын нутагт 10 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай нарны цахилгаан станц барихаар хэрэгжиж буй төслийн хүрээнд "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-д цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосноор Баруун бүсийн эрчим хүчний системд импортоор авч буй цахилгаан эрчим хүчний хэмжээг жилд 23.9 сая кВт-аар бууруулах боломж бүрдэж байна. Эрдэнэбүрэнгийн УЦС нь 50МВт ийн суурилагдсан хүчин чадалтай тусгай зөвшөөрлөө авсан байна.

Мөн 2022 онд 29.4 МВт-ын нийлбэр чадал бүхий биомассын 2 станц, 60 МВт-ын нийлбэр чадал бүхий эрчим хүч хуримтлуурын 2 станц барих тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж, тусгай зөвшөөрлүүдийг олгосон болно.

Үүнийг дүгнэж авч үзвэл дээрх СЭХ-ний нийт 668 МВт суурилагдсан хүчин чадалтай эх үүсвэрүүд ашиглалтанд орвол эрчим хүчний системд илүү тустай, импортын цахилгааныг багасгаж болох нь харагдаж байна.⁹

ДҮГНЭЛТ

Эрчим хүчний салбар нь Монгол Улсын үндэсний аюулгүй, бие даасан байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий хөгжлийн тэргүүлэх салбарын нэг. Монгол Улсын эрчим хүчний систем нь төвийн бүсийн нэгдсэн систем (ТБНС), баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС), Алтай-Улиастайн эрчим хүчний систем (АУЭХС), дорнод бүсийн эрчим хүчний систем (ДБЭХС), өмнөд бүсийн цахилгаан хангамж (ӨБЦТС) гэсэн таван хэсгээс бүрддэг.

2022 оны байдлаар Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд Сэргээгдэх эрчим хүчний 11 эх үүсвэр үйл ажиллагаагаа явуулж байна. ТБНС-д 3 Салхин цахилгаан станц холбогдон нийт 155МВт суурилагдсан хүчин чадалтай, 6 Нарны цахилгаан станц холбогдсон, нийт 95 МВт суурилагдсан хүчин чадалтай, 2 Усан цахилгаан станц холбогдон, нийт 23 МВт суурилагдсан хүчин чадалтай байна.

Монгол улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 10340.1 сая кВт.ц болж өнгөрсөн оноос 5.46%-иар өссөн ба нийт үйлдвэрлэсэн цахилгааны 90.84%-ийг дулааны цахилгаан станцаар, 9.16% ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хангасан байна.¹⁰

⁹ [ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2022 ОНЫ ТАЙЛАН](#)

¹⁰ Эх үүсвэр: Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2022

9.16% ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хангасан байна. Үүнд 23.9%-ийг нар, салхины эх үүсвэрээр, 67.9%-ийг усан цахилгаан станцаар, 8.2%-ийг дизель станцаар тус тус бүрдүүлсэн байна. Мөн Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр 2020 онд 649.4 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлсэн бол 2022 онд 749.9 сая кВт.цаг болж 100.5 сая кВт.цагаар нэмэгдсэн байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд системд холбогдоогүй байх үед - 92.7%-ийг ДЦС-ууд, 7.3%-ийг импортоор Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд системд холбогдсоноор дотоодын түгээлтийн хэмжээ 92.7 – 96.9% хүртэл өсч, импортын эрчим хүчээр хэрэглээний 3.1 – 7.3 %-ийг хангадаг болсон байна. Эдгээр СЭХ-ний эх үүсвэрүүд ТБЭХС – холбогдсоноор 2022 оны байдлаар импортын цахилгаан эрчим хүчнийг 7.3% иар бууруулахад гол үүрэг гүйцэтгэсэн нь харагдаж байна.

2022 оны Нэгдсэн сүлжээний өвлийн их ачаалал 1469 МВт ба энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 101 МВт буюу 9.9 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Энэ өсөлт нь системийн томоохон хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн мөн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын хэрэглэгчдийн халаагуурыг цахилгаанаар халдаг төхөөрөмжөөр шийдсэнтэй холбоотой гэж үзэж байна. Оргил ачаалалд Шанд СЦС 3.6%, Цэций СЦС 3.3%, Салхит 2.5% ийн оролцоотой ажилласан байна. СЭХ-ний тусгай зөвшөөрөл авсан нийт 668 МВт суурилагдсан хүчин чадалтай эх үүсвэрүүд ашиглалтад орвол эрчим хүчний системд илүү тустай, импортын цахилгааныг багасгаж болох нь харагдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Эх үүсвэр: Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2022
2. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг 2015, УБ хот
3. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого
4. Эрчим хүчний статистик үзүүлэлт, тайлан
5. National dispatching center 2023 page 16
6. Эх үүсвэр: Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2021
7. Диспетчерийн зохицуулалт, горим төлөвлөлт 2021 он
8. Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд (2014-2020).., ЭХЗХ-ны эмхэтгэл [3]: 8-16
9. <https://ndc.energy.mn/>
10. <https://online.fliphtml5.com/seigx/iivw/#p=1>

ГРАФ ӨГӨГДЛИЙН САН БОЛОН УЛАМЖЛАЛТ ӨГӨГДЛИЙН САНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

П.Зоригтбаатар¹

Мандах Их Сургууль – Мэдээлэл, Технологийн

Сургууль E-майл: zorigoo@mandakh.edu.mn¹

ХУРААНГУЙ

Бид бүхэн технологийн гайхамшигтай хөгжлийн эрин үед амьдарч байна. Хэдхэн секундын дотор дэлхий даяар сая сая мэдээлэл бий болж, боловсруулагддаг. Өгөгдлийн сангийн шинэ загваруудыг хөгжүүлэх хэрэгцээ нь динамик болон хадгалагдаж буй өгөгдлийн хэмжээтэй холбоотой юм. Бодит ертөнцөд болж буй өөрчлөлтөд хурдан дасан зохицдоггүй мэдээллийн сангийн схемийг ашиглах нь үр дүнгүй, заримдаа зүгээр л боломжгүй байдаг. Эдгээр бүх асуудлын шийдэл нь граф мэдээллийн сан байж болох юм.

ТҮЛХҮҮР ҮГС: *граф өгөгдлийн сан, өгөгдлийн сангийн загварчлал, өгөгдлийн сангийн оновчлол*

ОРШИЛ

Уламжлалт өгөгдлийн сангийн удирдлагын систем нь 1970-аад онд анх бий болсон. Түүнээс хойш уламжлалт өгөгдлийн сангийн нэр хүнд огцом өсч, энэ нь үндсэндээ эрдэм судалгаа, шинжилгээний болон арилжааны систем зэрэг бараг бүхий салбарт өгөгдлийг хадгалах стандарт бүтэц болсон. Уламжлалт өгөгдлийн сан нь SQLite гэх мэт жижиг өгөгдлийн сангаас эхлээд MSSQL Server, PostgreSQL, Oracle зэрэг том хэмжээний өгөгдлийн сангийн серверүүд хүртэл байдаг.

Граф өгөгдлийн сангийн судалгаа 1990-ээд оны эхээр түгээмэл байсан боловч hypertext болон XML судалгааны өсөлт зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас зогссон. Интернэтийг олон нийтэд зориулсан хэрэгсэл болгон хөгжүүлснээр өгөгдөл нь эзлэхүүн болон харилцан уялдаатай байдлаар нэмэгдэж эхэлсэн. Граф загварчлалыг өмнө нь илүү их хэмжээний өгөгдлийг илэрхийлэхэд ашигладаг байсан. Уламжлалт өгөгдлийн сангууд граф өгөгдөлтэй ажиллах чадвартай байдаг ч ихэвчлэн тийм зориулалтаар бүтээгдээгүй аль эсвэл маш муу үр дүн үзүүлдэг байна. Иймээс граф өгөгдлийн сангийн хэрэгцээ тодорхой болж, үүний судалгаа үргэлжилсэн байдаг.

ЗОРИЛГО

Уламжлалт өгөгдлийн сан болон сүүлийн жилүүдэд ихээхэн хөндөгдөх болсон граф өгөгдлийн сангийн хоорондын ялгаа, хэрэглээ, цаг зарцуулалт болон цаашдын хөгжүүлэлтийн ирээдүйг харьцуулан нэгтгэхийг зорив.

1. ГРАФ ӨГӨГДЛИЙН САН

Граф өгөгдлийн сан нь ямарваа нэгэн өгөгдлийг сүлжээний граф хэлбэрээр хадгалдаг NoSQL өгөгдлийн сан юм. Граф өгөгдлийн сан нь өгөгдлийг илэрхийлэх эсвэл хадгалах зориулалт бүхий зангилаа (nodes), ирмэг (edges), шинж чанар (properties) гэсэн ерөнхий зүйлүүдээс тогтдог. Граф өгөгдлийн санд байх холбоо хамаарал (relationships=edges) нь өвөрмөц түлхүүрүүдээр тодорхойлогддог бөгөөд ингэснээр өгөгдлийг илүү үр дүнтэй хадгалах, сэргээх, дамжуулах боломжтой. Уламжлалт өгөгдлийн санаас бүтцийн хувьд нягт биш, зангилаанууд нь олон ирмэгтэй (edges) байхыг зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, албан ёсны хязгаарлалт, стандартчлалгүй тул зангилаанд байж болох холбоо хамааралын тоонд хязгаарлалт байхгүй. Мөн ирмэг бүр тэдгээрийг тодорхойлох хэд хэдэн шинж чанартай байж болно. Граф өгөгдлийн сан нь нарийн төвөгтэй холбоо хамаарал бүхий өгөгдлүүдтэй харьцахдаа маш сайн байдаг тул нийгмийн сүлжээ, зар сурталчилгааны систем, залилан илрүүлэгч гэх мэт бусад олон програмуудад ихээхэн хэрэглэгддэг байна.

2. NoSQL

Сүүлийн жилүүдэд програм хангамж хөгжүүлэгчид уламжлалт өгөгдлийн сангаас өөр хадгалах хувилбаруудыг судалж байна. NoSQL нь эдгээр шинэ системүүдийн заримыг хамарсан ерөнхий нэр томъёо юм. Cassandra, BigTable, CouchDB, Project Voldemort, Dynamo нь бүгд NoSQL төслүүд бөгөөд тэдгээр нь бүгд их хэмжээний өгөгдлийг хадгалахдаа уламжлалт болон объектын хамаарлын загваруудыг ашиглахаас зайлсхийдэг байна.

Атом чанар, тууштай байдал, тусгаарлалт, бат бөх чанар (A – Atomicity, C- Consistency, I – Isolation, D - Durability) нь харилцааны загварын удирдах зарчмуудын багц юм. Эдгээр нь хамтдаа өгөгдлийн сангийн найдвартай байдлыг баталгаажуулдаг.

Харин NoSQL нь ACID-аас татгалздагаараа онцлогтой юм. Орчин үеийн вэб өгөгдлийг агуулдаг нэр томъёо болох "NoSQL" нь 2009 оны эхээр анх дэлгэрч эхэлсэн. Энэ нь Мэдээлэл, Технологийн нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн боловч томоохон хэмжээний эрдэм шинжилгээний судалгаа хийгдээгүй байгаа сэдэв юм. Гэсэн хэдий ч NoSQL хөдөлгөөн нь өөрийн гэсэн хэлэлцүүлгийн бүлгүүд, блогууд, төрөл бүрийн бага хуралтай. Ерөнхийдөө өгөгдлийн сангийн ердийн администратор нь уламжлалт загвараас NoSQL загвар руу шилжих эсэх талаар эргэлзэх оролдлого хийх үед NoSQL нийгэмлэг нь дараах өгөгдөл нь NoSQL системд илүү тохиромжтой байж болзошгүй гэсэн хэд хэдэн боломжуудыг танилцуулдаг байна.

1. Маш олон багана агуулсан хүснэгтүүдтэй байх бөгөөд тус бүрийг нь хэдхэн мөр ашигладаг үед.
2. Шинж чанарууд агуулсан хүснэгттэй байх үед.
3. Олон-олон (*-*) холбоо хамааралтай байх үед.
4. Мод шиг шинж чанартай байх тохиолдолд.
5. Схемийг байнга өөрчлөхийг шаарддаг байх үед

Өгөгдлийн гарал үүсэл нь дээрх шалгууруудын хэд хэдэн нөхцлийг хангаж байгаа тохиолдолд гарал үүслийг хадгалах асуудлыг шийдвэрлэх NoSQL шийдлүүдийг судлах нь зүйтэй юм.

3. Neo4j (НЕО ТЕХНОЛОГИ)

Neo4j нь өгөгдлийг граф хэлбэрээр загварчлан хадгалдаг бүрэн гүйлгээний өгөгдлийн сан (ACID) бөгөөд "Дэлхийн тэргүүлэгч граф өгөгдлийн сан" гэж нэрлэгддэг. Анхны хувилбар нь 2007 онд гарсан. Neo4j нь GPLv3 Community-д байдаг нээлттэй эхийн төсөл бөгөөд AGPLv3 болон арилжааны лицензийн дагуу Нарийвчилсан болон Аж ахуйн нэгжийн хувилбаруудыг ашиглах боломжтой. Neo4j бол аж ахуйн нэгжийг байршуулах хамгийн сайн граф өгөгдлийн сан юм. Энэ нь сүлжээн дэх олон тэрбум зангилаа, холбоо хамаарлыг хамардаг. Neo4j нь гүйлгээний өгөгдлийг өөрчлөх бүх үйлдлийг удирддаг. Neo4j-д зангилаа болон холбоо хамаарал хоёулаа шинж чанарыг агуулж болно. Neo4j нь граф икийг удирддаг өгөгдлийн сан бөгөөд хүснэгтийн оронд граф икийн бүтцэд зориулагдсан. Энэ нь бусад граф загваруудтай төстэй граф өгөгдлийн сангийн илүү илэрхийлэлтэй төрөл юм. Neo4j бол өнөөдрийн хамгийн алдартай граф өгөгдлийн сан юм.

Rank			DBMS	Database Model	Score		
Nov 2022	Oct 2022	Nov 2021			Nov 2022	Oct 2022	Nov 2021
1.	1.	1.	Oracle +	Relational, Multi-model	1241.69	+5.32	-31.04
2.	2.	2.	MySQL +	Relational, Multi-model	1205.54	+0.17	-5.98
3.	3.	3.	Microsoft SQL Server +	Relational, Multi-model	912.51	-12.17	-41.78
4.	4.	4.	PostgreSQL +	Relational, Multi-model	623.16	+0.44	+25.88
5.	5.	5.	MongoDB +	Document, Multi-model	477.90	-8.33	-9.45
6.	6.	6.	Redis +	Key-value, Multi-model	182.05	-1.33	+10.55
7.	7.	↑ 8.	Elasticsearch	Search engine, Multi-model	150.32	-0.74	-8.76
8.	8.	↓ 7.	IBM Db2	Relational, Multi-model	149.56	-0.10	-17.96
9.	9.	↑ 11.	Microsoft Access	Relational	135.03	-3.14	+15.79
10.	10.	↓ 9.	SQLite +	Relational	134.63	-3.17	+4.83
11.	11.	↓ 10.	Cassandra +	Wide column	118.12	+0.18	-2.76
12.	↑ 13.	↑ 18.	Snowflake +	Relational	110.15	+3.43	+45.97
13.	↓ 12.	↓ 12.	MariaDB +	Relational, Multi-model	104.91	-4.40	+2.72
14.	14.	↓ 13.	Splunk	Search engine	94.23	-0.43	+1.92
15.	15.	↑ 16.	Amazon DynamoDB +	Multi-model	85.40	-2.95	+8.41
16.	16.	↓ 15.	Microsoft Azure SQL Database	Relational, Multi-model	83.66	-1.30	+2.34
17.	17.	↓ 14.	Hive	Relational	81.89	+1.29	-1.42
18.	18.	↓ 17.	Teradata	Relational, Multi-model	65.23	-0.84	-4.35
19.	↑ 20.		Databricks	Multi-model	60.89	+3.28	
20.	↓ 19.	↓ 19.	Neo4j +	Graph	57.30	-1.38	-0.68

Зураг 1. Алдартай өгөгдлийн сангуудын 2022 оны 11-р сарын зэрэглэл (db-engines.com)

4. СУБЪЕКТИВ ХЭМЖҮҮРҮҮД

Харьцуулахад ашигласан субъектив хэмжүүрүүд нь: төлөвшил, дэмжлэгийн түвшин, програмчлалын хялбар байдал, уян хатан байдал, аюулгүй байдал. Хэдий тоон үзүүлэлтийг тодорхойлоход хэцүү ч эдгээр шалгуурууд нь ямар төрлийн өгөгдлийн санг ашиглах, юуг хэрэгжүүлэх эсэхийг шийдэхэд чухал ач холбогдолтой юм. Шаардлагатай тохиолдолд бид тодорхой хэрэгжилтийн нэг хэсэг болох өгөгдлийн сангийн нэг төрөлтэй холбоотой асуудлуудыг тодорхойлдог.

4.1 Төлөвшсөн байдал/Дэмжлэгийн түвшин

Төлөвшил гэдэг нь тухайн систем хэдэн настай, хэр нарийн боловсруулагдсан эсэхийг хэлнэ. Нарийн боловсронгуй систем нь тогтвортой байдлыг хангах бөгөөд ингэснээр нэг дор олон алдаа илрүүлж, тэдгээрийг шалтгааныг олоход илүү цаг хугацаа зарцуулна гэсэн үг юм. Дэмжлэгийн түвшин өндөр байна гэдэг нь системийг боловсронгуй байдалд эерэгээр нөлөөлнө. Төлөвшилт нь ихэвчлэн дэмжлэгийн түвшинтэй пропорциональ байдаг. Илүү боловсорч гүйцсэн програмыг нь илүү олон хүн ашиглах нь гарцаагүй.

Уламжлалт өгөгдлийн сан нь ерөнхийдөө хамгийн их ашиглагддаг өгөгдлийн сангуудын нэг бөгөөд энэ нь олон жилийн туршид хэрэглэгдсээр ирсэн. Уламжлалт өгөгдлийн санг дэлхийн өнцөг булан бүрт олон төрлийн системүүдэд ашигладаг. Жишээлбэл, Oracle болон Microsoft хоёулаа арилжааны мэдээллийн баазын бүтээгдэхүүндээ өргөн дэмжлэг үзүүлдэг. Oracle болон Microsoft нь өгөгдлийн сангийнхаа үйл ажиллагааны гүйцэтгэлээрээ нэр хүндээ үнэлдэг бөгөөд цаашдын гүйцэтгэлээ хангах санхүүгийн чухал сэдэл бүхий аварга корпорациуд юм. Цаашилбал, харилцааны загвар зах зээлд нэвтрэн орох нь хэрэглэгчийн дэмжлэгийг нэмэгдүүлнэ гэсэн үг юм. Уламжлалт өгөгдлийн сан нь мэдээллийн сантай харилцах нэгдсэн хэл болох SQL-тэй байх нь ашигтай байдаг. SQL нь хэрэгжүүлэлтүүдийн хооронд тийм ч их ялгаатай байдаггүй тул аль нэг хэрэгжүүлэлтийн дэмжлэг нь ихэвчлэн бусад хэрэгжүүлэлтүүдэд хамааралтай байдаг. MySQL нь хувьд үндсэн компани болох Sun болон хэрэглэгчдийнхээ өргөн дэмжлэгийг авдаг.

Граф өгөгдлийн сан нь энгийнээр бол зах зээлд нэвтрэх чадамж багатай байдаг. Тэдний худалдаа арилжааны бизнесүүд ихэвчлэн жижиг байдаг. Тэд нэгдмэл хэлээр дутагдаж байгаа тул нэг хэрэгжилтийг дэмжих нь бусад хүмүүст тустай биш байх магадлалтай. Ялангуяа Neo4j нь ашгийн төлөө орчинд хэрэглэгдэх юм бол арилжааны нэгэн хөдөлгүүр гэж болно. Мэдээж вэбсайт зэргүүдэд нь үндсэн толгой компани нь хангалттай хэмжээний дэмжлэг үзүүлдэг. Хэрэглэгчийн эсвэл нео нийгэмлэгийн дэмжлэгийн ихэнх хэсгийг Neo4j сайтын вики дээрээс авдаг. Дэмжлэгийн хувьд Neo4j сайтаас гаднах орчинд хязгаарлагдмал тул хэрэв Neo4j компани хэзээ нэгэн цагт сүйрвэл ихэнх дэмжлэг нь мөн сүйрнэ гэсэн үг юм. Хэдийгээр тэдний дэмжлэг болсон нийгэмлэгийн дуу хоолой багагүй байдаг ч граф өгөгдлийн сангийн хэрэглэгчийн дэмжлэг нь уламжлалт өгөгдлийн сантай харьцуулахад асар том ялгаатай байдаг.

4.2 Програмчлалын хялбар байдал

Уламжлалт өгөгдлийн сан нь SQL ашигладаг. Үүний нийтлэг хэл нь граф мэдээллийн баазтай харьцуулахад хэрэгжүүлэлт хооронд шилжилт хөдөлгөөн хийхэд хялбар болгодог. Граф өгөгдлийн сан нь хэлний онцлогтой бөгөөд өөрийн API-тай. Тиймээс граф өгөгдлийн сан хооронд шилжих нь уламжлалт өгөгдлийн сангаас хамаагүй ярвигтай байдаг.

Програмчлалын бодит хялбар байдал нь хийгдэх үйл явцаас хамаарна. Neo4j дээр граф дамжуулалт маш энгийн байдаг. Neo4j API нь үүнийг хийх процедур аргуудыг агуулдаг. MySQL граф икийн хөндлөн огтлолцол нь илүү төвөгтэй бөгөөд граф икаар давтагдах эсвэл давтагдах замаараа маш их хэмжээний холболтуудыг хийх магадлалтай.

Хүснэгтийг тодорхой атрибутын утгыг сканнердах нь энгийн WHERE заалтаас бүрдэх боломжтой тул уламжлалт өгөгдлийн сангийн хувьд маш хялбар байж болно. Граф өгөгдлийн сангийн тусламжтайгаар хайлт хийх хүсэлтийн гүйцэтгэл нь ашигласан индексжүүлэх үйлчилгээтэй нягт холбоотой байдаг. Neo4j нь бүрэн текстийг индексжүүлэхэд оновчтой болсон Lucene-г ашигладаг. Харин тоон болон огноо зэрэг бусад төрлийн өгөгдлийг сэргээх нь үр ашиг багатай байдаг.

Уламжлалт өгөгдлийн сан нь граф өгөгдлийг хадгалах чадвартай байдаг бөгөөд зарим жижиг програмчлалын тусламжтайгаар уламжлалт хадгалалтыг хэрэглэгчдэд ил тод болгохын тулд граф интерфэйсийг үүсгэж болдог. Граф өгөгдлийн сан нь зарим нэг хамаарлын өгөгдлийг орхигдуулдаг. Хэрэглэгчийн тэмдэглэл эсвэл ямар нэгэн захиалгын өгөгдлийн санг граф загварт оруулснаар ойлгоход илүү хэцүү болдог. Өгөгдлийн гарал үүсэл нь угаасаа граф боловч гарал үүслээс гадуур энэ нь асар том асуудал болж хувирдаг.

4.3 Програмчлалын уян хатан байдал

Уламжлалт болон граф өгөгдлийн сан нь зориулалтын орчинд маш сайн ажилладаг. Уян хатан байдал нь тэдгээр орчноос гадуур хэр сайн ажиллаж байгаагийн хэмжүүр юм.

Neo4j нь жижиг, хөнгөн, үр ашигтай. Java-ийн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд энэ нь серверийн програмуудтай холбоотой нэмэлт зардалгүй боловч серверийн хэмжээнд сайн ажиллах чадвартай хэвээр байна.

MySQL бол том хэмжээний олон хэрэглэгчийн орчинд ажиллах зориулалттай том сервер програм юм. Хэдийгээр үр ашигтай, маш оновчтой хэвээр байгаа боловч жижиг програмуудын хувьд хэрэглэгчид жижиг хэрэглэгчдэд ашигтай байх албагүй функцүүдийн зарим нэмэлт зардлыг хүлээн авах ёстой болдог. Жишээлбэл, мод бэлтгэх нь банк санхүүтэй огт хамааралгүй шиг энгийн хэрэглэгчдэд тийм ч чухал биш байж болно.

Neo4j нь амархан өөрчлөгддөг схемтэй бол уламжлалт өгөгдлийн сан нь өөрчлөгддөггүй. Өгөгдлийн санг байршуулсны дараа MySQL схемийг өөрчлөх боломжтой боловч үүнийг хийх нь Neo4j-ээс хамаагүй илүү ярвигтай, нэлээдгүй хүчин чармайлт шаарддаг ажил юм.

4.4 Аюулгүй байдал

Уламжлалт өгөгдлийн сан нь ерөнхийдөө болон тэр дундаас MySQL нь олон хэрэглэгчийн өргөн хүрээний дэмжлэгтэй байдаг. Нөгөөтэйгүүр, граф өгөгдлийн сангуудад олон хэрэглэгчийн орчинд ажиллахад ихээхэн дэмжлэг байдаггүй. Neo4j ч мөн тэдний дунд. Энэ нь бүх хэрэглэгчийн удирдлагыг хэрэглээний түвшинд зохицуулахыг албаддаг.

Нэмэлт програмуудын тал дээр Neo4j-д аюулгүй байдлын дэмжлэг бүхий хамгаалалт байхгүй. Харин MySQL нь олон төрлийн өгөгдлийн сангийн нэгэн адил ACL-д суурилсан аюулгүй байдлын өргөн дэмжлэгийг агуулдаг.

5. ХАРЬЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Энэхүү харьцуулалт дээр олон судалгаа дундаас хамгийн нарийн, нягт хийгдсэн Польш улсын Честоховагийн Технологийн Их Сургууль - Компьютер, Мэдээллийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн оюутан Малгорзата Лазарска болон Ольга Сиедлечка-Ламч нарын хийсэн судалгааны ажлын хүрээнд хоёр төрлийн өгөгдлийн санг (Oracle – relational database-н төлөөлөл, Neo4j – граф өгөгдлийн сангийн төлөөлөл) харьцуулан судалсан. Логик загварчлал нь хоёр төрлийн өгөгдлийн сангийн хувьд энгийн бөгөөд ойлгомжтой байсан ба цорын ганц ялгаа нь граф өгөгдлийн санд уламжлалт өгөгдлийн сангаас холбоо хамаарлын тусгалыг хадгалах хэрэгцээ байсан. Үүний зэрэгцээ граф загвар нь илүү уян хатан бөгөөд нарийн төвөгтэй өгөгдөл, холбоо хамаарлыг оруулах боломжийг олгодог. Мөн тэд нэг загварыг нөгөө загварт хэрхэн хувиргаж болохыг харуулсан. Граф загварт шинэ шинж чанаруудыг нэмэх нь илүү хялбар байдаг бол ажлын орчин дахь уламжлалт өгөгдлийн санд шинэ шинж чанаруудыг нэмэх нь маш хэцүү эсвэл боломжгүй байх нь олонтаа. Хоёр өгөгдлийн санг өөр өөр талаас нь харьцуулахын тулд гурван төрлийн туршилт хийсэн ба үр дүнд нь граф бүтцэд илүү хурдан байснаараа онцлогтой гэж дүгнэв. Нийтдээ 10,000,000 гаруй өгөгдлийн сантай датабаз дээр хийгдсэн туршилтаас харвал:

Хүснэгт 1. Нийлмэл хүснэгт/төрлөөс хамааралтай туршилт

Нийлмэл хүснэгтүүд/төрлүүд	Oracle		Neo4j	
	Query цаг SQL [сек]	Бүлэглэлт	Query цаг Cypher [сек]	Нийт датабазын хандалт
1	0,083	2	0,180	1 001 079
2	0,085	5	0,184	1 001 083
3	0,084	8	0,181	1 001 087
4	0,257	1 200 009	0,190	1 001 098
5	0,248	1 200 012	0,187	1 001 106
6	0,568	4 200 013	0,195	1 001 141
7	0,863	7 300 017	0,203	1 001 241

Хүснэгт 2. Өгөгдөл/зангилааны хязгаарлалтаас хамааралтай туршилт

Нийт буцаасан өгөгдөл	Oracle		Neo4j	
	Query цаг SQL [сек]	Бүлэглэлт	Query цаг Cypher [сек]	Нийт датабазын хандалт
1	0,042	18	0,001	28
10	6,077	3 100 041	0,001	133
100	24,912	7 758 088	0,003	1 256
1 000	26,477	7 789 966	0,018	12 486
10 000	47,459	8 730 196	0,137	124 743
100 000	111,322	10 201 522	2,206	1 247 379

Хүснэгт 3. Өгөгдөл өөрчлөх үйл явцын туршилт

Хүснэгт/төрөлжсөн зангилааны хэмжээ	Oracle		Neo4j	
	Query цаг SQL [сек]	Бүлэглэлт	Query цаг Cypher [сек]	Нийт датабазын хандалт
100 000	0,183	2	0,001	1
400 000	0,236	2	0,001	1
500 000	0,238	2	0,001	1
1 200 000	0,425	2	0,001	1
3 000 000	0,564	2	0,001	1
3 100 000	0,578	2	0,001	1

ДҮГНЭЛТ

Хоёр систем хоёулаа өөр өөрийн гэсэн давуу болон сул талуудтай. Жишээ нь: Уламжлалт буюу холбоост өгөгдлийн сан урт хугацааны турш ашиглагдаж ирсэн, стандарт нэгдсэн хэлтэй бол граф өгөгдлийн сан нь илүү уян хатан байна. Олон холбоо хамааралтай мэдээлэл дундаас хайлт хийхэд граф өгөгдлийн сангууд уламжлалт өгөгдлийн сангаас илүү хурдан байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Өгөгдлийн сангийн системийг сонгоход гол үүрэг гүйцэтгэх ёстой өөр нэг хүчин зүйл бол аюулгүй байдал бөгөөд neo4j энэ тал дээр сул үзүүлэлттэй байна. Үйлдвэрлэлийн орчинд граф мэдээллийн санг ашиглах нь эрт байна. Нэмж дурдахад хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах хэрэгцээ зайлшгүй шаардлагатай. Neo4j-д аюулгүйн дэмжлэг үзүүлдэггүй нь мэдэгдэхүйц сул тал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] <https://en.wikipedia.org>
- [2] <https://github.com/mustafamuratcoskun/neo4j-benchmark-test>
- [3] <https://neo4j.com/graphgists/cypher-vs-sql/>
- [4] <https://www.g2.com/categories/graph-databases>
- [5] “Neo4j in Action” By Jonas Partner, Aleksa Vukotic, and Nicki Watt
- [6] “Comparative study of relational and graph databases” by Malgorzata Lazarska, Olga Siedlecka-Lamch
- [7] “A Survey on Graph Database Management Techniques for Huge Unstructured Data” by Patil N. S. , Kiran P , Kavya N. P. , Naresh Patel K. M.

НББОУС12 “ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР” СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА

С.Цэвээнжаргал^{1a}, М.Энхсүрэн^{2b}, Г.Хандсүрэн^{3c}, Т.Золбоо^{4d}, Э.Энх-Амгалан^{5e}

¹Мандах ИС, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

²Мандах ИС, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

³Мандах ИС, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

⁴Мандах ИС, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

⁵Мандах ИС, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

^aTseveenjargal@mandakh.edu.mn

^bEnkhsuren@mandakh.edu.mn

^cKhandsuren@mandakh.edu.mn

^dT_Zolboo@mandakh.edu.mn

^eEnkhamgalan@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монгол улсад НББОУС12 “Орлогын албан татвар” стандартын хэрэгжилтийг судлахыг зорьсон. Бид 2 таамаглал дэвшүүлж, таамаглал тус бүрийг илэрхийлэх үндсэн 24 асуулт болон ерөнхий 7 асуулт бэлтгэж, аудиторууд болон аудиторын туслахуудыг судалгаанд хамруулсан.

Судалгаанд нийт 77 хүн хамрагдсан бөгөөд Spss программ ашиглан *descriptive statistics*, *reliability analysis*, мөн *t-тест*ээр үр дүнг үнэлсэн. Судалгааны үр дүнд Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд нь НББОУС12-т нийцүүлэн байнгын болон түр зөрүүг бүртгэж тайлагнадаг гэсэн нэгдүгээр таамаглалын асуултын дундаж үнэлгээ өндөр байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, тусгай хувь хэмжээтэй орлого, хасагдахгүй зардалтай холбоотой байнгын зөрүүг зөв бүртгэж тайлагнах асуултын үнэлгээ өндөр байсан бол хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөрийг бүртгэх, дундаж татварын түвшинг ашиглан татварыг бүртгэх асуултын үнэлгээ дундаж байсан. Хэдийгээр Аж ахуйн нэгж байгууллагууд орлогын албан татвартай холбоотой зөрүүг бүртгэж тайлагнаж байгаа боловч санхүүгийн тайланд толилуулагддаг данс тус бүрийн хувьд НББОУС 12-той нийцтэй байдал дундаж түвшинд байсан. Иймд бид НББОУС12 “Орлогын албан татвар” стандартыг хэрэгжилтийг дунд гэж дүгнэсэн.

Түлхүүр үг: Байнгын зөрүү, түр зөрүү, хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өр

ОРШИЛ

Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 4.2-т заасан аж ахуй нэгжүүд нь Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт /СТОУС/-ыг дагаж мөрдөхөөр хуульчилсан байдаг. Монгол Улсад СТОУС-ын нэвтрэлт, хэрэгжилтийг үнэлэх хэд хэдэн удаагийн улсын үзлэг, тооллого, судалгаа хийгдсэн байна. Хамгийн сүүлд 2019 онд Сангийн яамнаас хэрэгжүүлсэн “Улсын үзлэг”-ээр стандартын нэвтрэлт 43% байсан.

Орлогын татварын стандарт нь анх олон улсад НББОУС12 “Орлогын албан татвар” нэртэйгээр 1996 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Улмаар Монгол Улсын хувьд Сангийн сайдын 1997 оны 429 тоот тушаалаар “Санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан хоорондын уялдааг зохицуулах журам”-ыг мөрдөж эхэлсэн.

Татварын бүртгэл нь санхүүгийн бүртгэлийг татварын суурьт нийцүүлэн холбогдох татварын хууль тогтоомжийн дагуу төлөх ёстой татварын хэмжээг тодорхойлоход чиглэгдэг учраас мэдээлэл хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ шаардлагыг бүрэн гүйцэт хангаж чаддаггүй. СТОУС-ын үзэл баримтлалын дагуу нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан нь мэдээлэл хэрэглэгчдийг ач холбогдолтой санхүүгийн мэдээллээр хангах явдал байдаг. Иймд мэдээлэл хэрэглэгчдийг СТОУС-д нийцсэн чанартай санхүүгийн мэдээллээр хангах нь чухал юм.

НББОУС12 “Орлогын албан татвар”-ын хэрэгжилт нь СТОУС-д хамаарах бусад стандартуудын нэвтрэлт, хэрэгжилтээс хамааралтай ба энэ нь СТОУС-ын үзэл баримтлал, зарчмын дагуу илэрхийлэгдсэн санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн татварын нөлөөллийг бүртгэх НББ-ийн арга зүйг тодорхойлсон стандарт юм. Санхүүгийн тайланд толилуулсан данс тус бүрийн хувьд холбогдох стандартын дагуу үнэн зөв бүртгэгдсэн тохиолдолд хууль тогтоомж ба СТОУС-ын хооронд зөрүү үүснэ. Тус зөрүүг бүртгэж тайлагнах асуудал нь Монгол Улсад төдийгүй Олон Улсад нягтлан бодох бүртгэлийн практик, судалгаанд маргаан дагуулсаар байна. (Anna Görnitz, Michael Dobler, 27 September 2021) Иймээс бид СТОУС-г нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажилд өөрсдийн хувь нэмрийг оруулахын тулд НББОУС12 “Орлогын албан татвар”-ийн хэрэгжилтийн талаарх судалгааг хийлээ.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Аудитор болон аудиторын туслахуудын ажлын туршлага, мэргэжлийн шийдэлд үндэслэн НББОУС12 “Орлогын албан татвар” стандартын хэрэгжилтийг үнэлэх

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- НББОУС12 “Орлогын албан татвар” болон Монгол Улсын татварын хууль тогтоомжоос үүсэх зөрүүг судлах
- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аудитын компаниудын аудитор, аудиторын туслахуудаас НББОУС12 “Орлогын албан татвар” хэрэгжилтийн талаарх асуулга авах

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Санхүүгийн тайлагналын зорилгоор тооцсон орлогын албан татварын зардал болон татварын тайлагналын зорилгоор тооцсон орлогын албан татварын зардлын зөрүүгээс үүдэлтэй хойшлогдсон татвар нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зохицуулалт, практик, судалгаанд удаан үргэлжилсэн маргаантай асуудал байсаар ирсэн. Үзэл баримтлал, стандартын талаарх мэтгэлцээнүүд хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд холбогдох мэдээллээр хангадаг эсэх, мөн компаниуд ашиг орлогоо удирдахад ашигладаг эсэх талаар эргэлзээ үүсгэдэг. Сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа судалгааны ажлууд ихэвчлэн АНУ-ын нөхцөлд анхаарал төвлөрүүлж ашгийн удирдлагад хойшлогдсон татварыг ашигладаг гэсэн таамаглалыг нотлохыг зорьсон хандлагатай байна. (Anna Görlitz, Michael Dobler, 27 September 2021)

Шинэ Зеландад НББОУС 12-ыг нэвтрүүлэхээс өмнөх болон дараах хойшлогдсон татварын хөрөнгийн хооронд мэдэгдэхүйц ялгаа байгааг Edeigba Jude нар тодорхойлсон. Хойшлогдсон татвар болон тайлбарлагч хувьсагчдыг харьцуулахын тулд Z онооны шинжилгээг хийсэн ба төгсгөлд нь T-Тест ба хамгийн бага квадратын аргаар регресс тооцсон. (Jude, 2022)

“Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС12) орлогын албан татвар”-ыг зүүн өмнөд азийн орнуудын үндэсний стандартай харьцуулсан судалгааг 2 үе шаттай буюу асуулга, ярилцлагын аргаар хийсэн байна. 1-р үе шатанд СТОУС-ын хэрэгжилт, сургалтын асуудлуудыг хөндсөн. 2-р үе шатанд НББОУС12 Орлогын албан татварын талаар нэмэлт судалгаа хийж, нягтлан бодох бүртгэлийн стандартууд нь татварын нийцлийн эхлэлийн нэг цэг бөгөөд орлогын албан татвар нь санхүүгийн тайлангийн нэг хэсэг болдог тухай судалсан. (Prem W.S. Yara, Diane Kraal Monash, Mahesh Joshi, 2015)

НББОУС12-ийн хэрэгжилт болон солонгосын үндэсний стандартыг харьцуулан, алдагдал шилжүүлэлтийн компаниудын ирээдүйн ашигт үзүүлэх нөлөөллийг судалсан. Алдагдлыг ирээдүйд шилжүүлж, хойшлогдсон татварын хөрөнгө бүртгэж байгаа компаниудын хувьд хөрөнгө оруулагч, удирдлагуудад эерэг дохио өгч, хувьцааны үнэ өсөхөд нөлөөлж байна гэж үзсэн. (Nanhee Hong, Junyong Shim, 2019)

Нигери улсын хадгаламжийн банкууд дахь НББОУС12-ийн нэвтрэлтийн судалгаагаар СТОУС-ыг нэвтрүүлэхээс өмнө болон дараа нь тайлагнасан татвар болон орлогын албан татварын хувь хэмжээ хооронд ихээхэн зөрүү байгааг олж тогтоосон. СТОУС-ыг нэвтрүүлэх нь ашигт ажиллагааны түвшинд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байгааг харуулсан. Энэхүү судалгаанд аливаа тодорхой стандартыг хэрэглэхдээ татварын үр дагаврыг, ялангуяа татварын хууль тогтоомж өөр өөр байдаг тул авч үзэхийг санал болгосон. (Patrick Amaechi Egbunike, Onyii Paulinus Okoye, 2017)

Marina Purina Чех болон ОХУ-ийн компаниудын НББОУС 12 - хойшлогдсон татвар судалгааны ажилдаа өөрийн таамаглалаа батлахын тулд Чех болон ОХУ-ийн биржид бүртгэлтэй компаниудын хойшлуулсан татварын тоон шинж чанарыг харьцуулж, болзошгүй зөрүү, тэдгээрийн шалтгааныг шинжилж үзсэн. Чехийн компаниудыг бүхэлд нь авч үзвэл хойшлогдсон татвартай холбоотой үзүүлэлтүүдийн стандарт хазайлт Орос компаниудтай харьцуулахад бага гарсан байна. (Purina, 2017)

НББОУС 12-ийн талаарх судалгаа хийхдээ аналитик ба синтетик, тоон болон чанарын шинжилгээ, санхүүгийн тайлангийн үндсэн шинжилгээ, бизнесийн үйл ажиллагааны

нягтлан бодох бүртгэлийн хос арга, мэргэжлийн дүгнэлтийн арга зэргийг ашигласан. Хойшлогдсон татварын өр төлбөр, хойшлогдсон татварын хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн талаарх маргаан тавин жил үргэлжилж байгаа ч асуудал буурахгүй, улам бүр нэмэгдсээр байгаа тухай дүгнэсэн. НББОУС12-ийн хэрэгжүүлэлтийг сайжруулснаар санхүүгийн тайлангийн чанар сайжирч, ААН-д хэт их зардлаас чөлөөлөгдөнө гэж үзсэн. (Chiladze, 2017)

“СТОУС ба Нигерийн-SAS-ын дагуу хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөх ба хэмжилтийн үнэлгээ” судалгаанд Нигерийн 15 үйлдвэрлэлийн компанийг түүвэрт хамруулан, санхүүгийн тайлангийн хоёрдогч мэдээлэлд тулгуурлан судалгаа хийсэн. Боловсруулсан таамаглалаа хосолсон түүврийн t-тест ашиглан шинжилж, хамаарлыг шалгахдаа шугаман регресс ашигласан. Судалгаагаар хойшлогдсон татварын хөрөнгө, татварын өр төлбөр, одоогийн татвар зэрэгт статистикийн мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан байна. Судалгааны үр дүнд Нигери улсын үндэсний стандарт болон СТОУС хооронд эерэг холбоо илэрсэн. (Ogbodo Cy. Okenwa, Egbunike Francis Chinedu, Abiahu Mary-Fidelis Chidoziem, 2017)

“СТОУС-ыг цэгнэхүй” судалгаанд СТОУС-ыг нэвтрүүлэхэд ААН-үүдэд тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох зорилгоор 7 асуулт бүхий асуулга бэлтгэж, хэрэгжилтийг судалсан байна. Тус судалгаагаар СТОУС-ын нэвтрэлт хангалтгүй гэж үзсэн байна. (Л.Дондог, 2017)

“Монгол улсын аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлагнал дахь үнэлгээний асуудал” өгүүлэлд 2022 онд нийт аж ахуйн нэгжүүдийн 1.2 хувь нь /918 аж ахуйн нэгж/ хойшлогдсон татвар бүртгэсэн бөгөөд тус стандартын хэрэгжилт муу байгаа тухай дурдсан байна. (Х.Нямбаяр, Ц.Намуун, 2023)

“Санхүүгийн тайлан, татварын тайлангийн зөрүүг зохицуулан бүртгэх нь” судалгааны ажилд НББОУС12-ийн дагуу зөрүүг бүртгэж тайлагнаж байгаа өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, түүний хэрэгжилтийг сайжруулах санал зөвлөмжөө илэрхийлсэн байна. (Г.Алтанзаяа, 2008)

“Иорданы орлогын албан татварын бүртгэл ба НББОУС 12-н нийцэл” судалгаанд нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр мэргэшсэн ахлах болон дунд шатны ажилтнуудыг хамруулан асуулга авсан байна. Тус улсын хувьд санхүүгийн тайланд хойшлогдсон татварыг толилуулдаггүй бөгөөд орлогын татварыг бүртгэхдээ СТОУС-ийн ихэнх шаардлагыг дагаж мөрддөггүй байна. (Abdallah, 2017)

Судалгаанд хамаарах СТОУС болон татварын хууль тогтоомжоос үүсэх зөрүү

Чөлөөлөгдөх орлого: Байнгын зөрүү үүсгэнэ. Санхүүгийн тайланд бүртгэгдсэн орлогыг татвар ногдуулах орлогоос хасаж орлогын татварын өрийг тодорхойлно. (ААНОАТ-ын тухай хууль, 2019)

Тусгай хувь хэмжээтэй орлого: Байнгын зөрүү үүсгэнэ. Татварын хууль тогтоомжоор тодорхойлсон хувиар орлогын албан татварын өрийг тодорхойлно. (ААНОАТ-ын тухай хууль, 2019)

Хөнгөлөгдөх орлого: Байнгын зөрүү үүсгэнэ. Татварын хууль тогтоомжоор тодорхойлсон хэмжээгээр хөнгөлөлт эдлүүлж, орлогын албан татварын өрийг тодорхойлно. (ААНОАТ-ын тухай хууль, 2019)

Зардлын хязгаарлалт: Санхүүгийн тайланд СТОУС-ын дагуу бүртгэгдсэн зарим зардлууд татварын тайланд хасагддаггүй. Зарим зардлууд тодорхой хэмжээний хязгаартайгаар хасагдаж орлогын татварын өрийг тодорхойлдог ба энэ нь түр эсвэл байнгын зөрүүг үүсгэдэг. (ААНОАТ-ын тухай хууль, 2019)

НББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулга: Стандартын гол зорилго нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайланг толилуулах ерөнхий шаардлагуудыг тодорхойлох юм. Орлогын татварын бүртгэлтэй холбоотойгоор санхүүгийн тайланд толилуулах тодруулах шаардлагатай зүйлсийг тус стандарт тодорхойлно. (МНБИ, 2021)

НББОУС2 Бараа материал: Бараа материалын бүртгэлийн хандлагыг тодорхойлно. Бараа материалын анхдагч хэмжилт болон дараа үеийн хэмжилтийн зөрүүнээс хойшлогдсон татварын түр зөрүү үүснэ. (МНБИ, 2021)

НББОУС8 Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, алдаа: Холбогдох НББ-ийн бодлогын өөрчлөлт болон өмнөх тайлант хугацааны алдааны залруулгаас шалтгаалан хойшлогдсон татварын өр, хөрөнгийн дүнд өөрчлөлт орох боломжтой. (МНБИ, 2021)

НББОУС 16 Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн анхдагч хэмжилт, дараа үеийн хэмжилт болон дараа үеийн зардлын зөрүүнээс хойшлогдсон татварын түр зөрүү үүсэхээс гадна зарим тохиолдолд байнгын зөрүү ч үүсэж болно. ААНОАТ-ын тухай хуулийн 17.4-т Эргэлтийн бус хөрөнгийг худалдан авах, барих, угсрах, тээвэрлэх болон тээвэрлэлттэй холбоотой даатгуулах зардлыг тухайн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох үнэлгээнд оруулж тооцно. Эргэлтийн бус хөрөнгийг тээвэрлэх болон тээвэрлэхтэй холбоотой даатгалын зардлаас бусад өртөгт хамаарах зардлууд нь татварын зорилгоор тайлант үеийн зардал болно. Иймд НББОУС 16-ийн дагуу тооцсон үндсэн хөрөнгийн өртөг нь татварын зорилгоорх өртгөөс зөрүүтэй байж болно. (МНБИ, 2021)

НББОУС21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө: Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарзыг НББОУС 21-ийн дагуу санхүүгийн тайланд шууд хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Харин татварын зорилгоор зөвхөн бодит ашиг, алдагдлыг татвар ногдуулах орлогын тооцоололд оруулж, орлогын татварын өрийг тодорхойлдог. (МНБИ, 2021)

СТОУС15 Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого: ААНОАТ-ын хуулийн дагуу барааг илгээсэн, эсхүл ачуулснаар; ажлыг гүйцэтгэлийн хувиар; үйлчилгээний орлогыг хүлээж авсан, эсхүл гэрээ, хэлцэлд заасан нөхцөлийг хангаснаар; бусад орлогыг бодитоор хэрэгжсэн, орлого орсон тухай бүр; албан татвар төлөгч бараа, ажил, үйлчилгээ солилцсон тохиолдолд бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан өдрөөр албан татвар ногдох орлогыг хүлээн зөвшөөрнө гэж заасан байна. Харин СТОУС 15 “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого”-д худалдан авагч талд хяналтын эрх шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө гэж үздэг. (МНБИ, 2021)

НББОУС 40 ХОЗҮХХ: ХОЗҮХХ-ийн бүртгэлийн хандлагыг тодорхойлно. Хөрөнгийн анхдагч хэмжилт, дараа үеийн хэмжилт болон дараа үеийн зардлын зөрүүнээс хойшлогдсон татварын түр зөрүү үүсэхээс гадна зарим тохиолдолд байнгын зөрүү ч үүсэж болно. (МНБИ, 2021)

НББОУС 23 Зээлийн өртөг: Бэлтгэл ажилдагаа хугацаа шаардагдсан хөрөнгийг барьж байгуулахад зориулан авсан зээлийн өртгийг тус стандартад капиталжуулахыг заасан байдаг. Харин татварын хуулийн дагуу зээлийн хүүгийн зардлыг хасагдах зардал гэж үзнэ. (МНБИ, 2021)

СТОУС 16 Түрээс: Ашиглах эрх бүхий хөрөнгийг бүртгэх шалгуур хангасан хөрөнгийн хувьд СТОУС-ын дагуу хүүгийн зардал болон элэгдлийн зардлыг бүртгэнэ. Харин татварын хуулийн дагуу зөвхөн элэгдлийн зардлыг тооцож, орлогын татварын өрийг тодорхойлсноор түр зөрүү үүснэ. (МНБИ, 2021)

СТОУС 3, СТОУС9, НББОУС 28, НББОУС 39: Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнээр хэмжих санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжиж тайлагнадаг. Хөрөнгө оруулалтын үнэлгээтэй холбоотой тайлант хугацааны эцэст олз, гарз үүсдэг энэ татварын тайланд түр зөрүү үүсгэнэ. (МНБИ, 2021)

НББОУС 37 Нөөц, болзошгүй зүйл: Нөөц болзошгүй өр төлбөртэй холбоотой зардлыг СТОУС-ын дагуу урьдчилан тооцож зардлаар хүлээн зөвшөөрдөг. Харин татварын хуулийн 13.1.3-т зардал бодитоор гарсан зардлыг хасагдах зардалд хүлээн зөвшөөрдөгтэй холбоотой түр зөрүү үүснэ. (ААНОАТ-ын тухай хууль, 2019) (МНБИ, 2021)

СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд СТОУС-ыг дагаж мөрдөнө гэж заасан байдаг ч Сангийн яамнаас 2019 онд хэрэгжүүлсэн “Улсын үзлэг”-ээр СТОУС-ын нэвтрэлтийг 43% гэж дүгнэсэн. СТОУС-ыг орчуулах, түүнийг нэвтрүүлэх ажил манай оронд эрчимтэй өрнөж байгаа ч хангалтгүй байгаа юм. Иймд бид судалгааны ажлын таамаглалыг дараах байдлаар дэвшүүлсэн.

Таамаглал 1: Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд нь НББОУС12-т нийцүүлэн байнгын болон түр зөрүүг бүртгэж тайлагнадаг.

Таамаглал 2: Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд нь НББОУС12-т нийцүүлэн орлогын албан татварыг бүртгэдэг.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

АОУС-д “Санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэгдсэн эсэх талаар санал дүгнэлтээ илэрхийлэх” нь аудиторын зорилго гэж тодорхойлсон байдаг. (ISA, 2009) Хууль болон стандартаар аудиторын мэргэжлийн ур чадварт өндөр түвшний шаардлага тавьдаг. Тухайлбал, Аудитор болохын тулд МНБ-ийн хугацаагүй эрхтэй байхаас гадна АОУС-аар СТОУС-ын талаарх гүнзгий мэдлэгтэй байхыг шаарддаг. Иймээс НББОУС 12 “Орлогын албан татвар” стандартын хэрэгжилтийн талаарх судалгаанд аудитор болон аудиторын туслахуудыг хамруулсан болно.

“Иорданы орлогын албан татварын бүртгэл ба НББОУС 12-ын нийцэл”-ийн судалгааны таамаглал бидний судалгааны таамаглалтай ижил агуулгатай байсан тул дээрх судалгаанд үндэслэн өөрсдийн судалгааны асуулгыг боловсруулсан. (Abdallah, 2017) Бид СТОУС болон Монгол Улсын татварын хууль тогтоомжуудын хооронд үүсэх зөрүү, онцлогт үндэслэн таамаглал 1-д хамаарах 9 асуулт, таамаглал 2-т хамаарах 15 асуулт бэлтгэсэн.

Fifth-Lickert Scale (Бүрэн санал нийлж байна-5, санал нийлж байна-4, зарим талаар санал нийлж байна-3, санал нийлэхгүй-2, огт санал нийлэхгүй-1) ашиглан судалгааг үнэлсэн бөгөөд тооцооллыг SPSS программыг ашиглан үр дүнг гаргасан болно.

Fifth-Lickert Scale-ийн статистикийн дунжийг ашиглан дүгнэлт гаргах шалгуурыг $(5-1/3=1.33)$ -ийг үндэслэн дараах байдлаар тооцсон. (Tucker-Seeley, 2008)

1. $M \geq 3.67$ Өндөр
2. $2.35 \leq M < 3.66$ Дунд зэрэг
3. $M < 2.34$ Бага

Статистик судалгаанд:

- Descriptive statistics (Ерөнхий статистик)
- Reliability analysis (Cronbach's alpha > 0.6 байхад асуулгуудыг найдвартай гэж үздэг)
- Т-тестээр үр дүнг гаргасан. (Z оноо өгч, one way test) (асуултуудын ялгаатай байдал)

Судалгаанд дэвшүүлсэн таамаглалуудын дагуу асуулгуудын найдвартай байдлыг Кронбахын Альфа тестээр шалгаж үзэхэд үр дүн дараах байдалтай байсан.

Хүснэгт 1. Кронбахын Альфа тестийн үр дүн

Reliability Statistics	Cronbach's Alpha	N of Items
Таамаглал 1-ын асуултууд	.866	9
Таамаглал 2-ын асуултууд	.936	15

Дээрх хүснэгтийн үр дүнгийн харахад таамаглал 1 болон 2-ын асуултуудын хувьд Cronbach's alpha > 0.6 -аас өндөр гарсан нь асуулгын найдвартай байдлыг харуулж байна.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Таны нас	Таны албан тушаал		Таны боловсролын зэрэг		Таны ажлын туршлага /ажилласан жил/			
	Аудитор	Аудиторын туслах	Бакалавр	Магистр	3 хүртэлх жил	3-6 хүртэлх жил	6-10 хүртэлх жил	10-с дээш
30 хүртэлх	13	8	18	3	10	7	4	0
30-40	25	1	11	15	1	2	4	19
40-50	15	1	6	10	0	1	0	15
50-60	14	0	6	8	0	0	0	14
Нийт	65	12	41	36	11	10	8	48
Эм	49	9	31	27	7	6	7	38
Эр	16	3	10	9	4	4	1	10
Нийт	65	12	41	36	11	10	8	48

Монгол улсын хэмжээнд 1000 гаруй аудиторууд бүртгэлтэй байдаг ба бид 90%-ийн ач холбогдлын түвшинд 64 аудитораас судалгааг авбал төлөөлөх чадвартай гэж үзээд тус судалгааг 65 аудитор, 12 аудиторын туслахыг хамруулан авсан. Судалгаанд хамрагдагсдын 53% нь Бакалаврын зэрэгтэй ба 62% нь 10-аас дээш жилийн ажлын туршлагатай хүмүүс байсан.

Хүснэгт 3. Таамаглал №1-ын асуултуудын T-тестийн үр дүн

Таамаглал 1	t	Sig	Mean Difference	Test Value = 2.5 95% Confidence Interval of the Difference	
				Lower	Upper
				Татвар төлөхийн өмнөх ашиг болон татвар ногдуулах орлогыг зөрүүтэй тайлагнадаг	6.097
Хойшлогдсон татварын хөрөнгө бүртгэж тайлагнадаг	3.861	.000	.455	.22	.69
Хойшлогдсон татварын өглөг бүртгэж тайлагнадаг	3.726	.000	.455	.21	.70
Чөлөөлөгдөх орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	4.801	.000	.584	.34	.83
Тусгай хувь хэмжээтэй орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	5.534	.000	.688	.44	.94
Хөнгөлөгдөх орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	5.093	.000	.597	.36	.83
Хасагдахгүй зардалтай холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	5.661	.000	.688	.45	.93
Хасагдах зардалд тавигдах шаардлагатай холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	4.692	.000	.545	.31	.78
Дундаж татварын түвшинг ашиглан хойшлогдсон татварыг зөв бүртгэж тайлагнадаг	.191	.849	.026	-.24	.30

Хүснэгт №3-ийн үр дүнг харвал таамаглал 1-тэй холбоотой 9 асуултаас тооцооны t утга нь хүснэгтийн t утгаас өндөр байгаа тул асуултуудын дундаж хариулт хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Таамаглал №2-ын асуултуудын T-тестийн үр дүн

Таамаглал 2	t	Sig	Mean Difference	Test Value = 2.5 95% Confidence Interval of the Difference	
				Lower	Upper
				Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлтийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтээс үүссэн татварын зөрүүг НББОУС 12-т нийцүүлэн бүртгэдэг	2.634
Орлогын татварын бүртгэлтэй холбоотой шаардлагатай тодруулгыг НББОУС12-ын дагуу бэлтгэдэг	-5.094	.000	-.545	-.76	-.33
Орлогын татварын бүртгэлтэй холбоотой шаардлагатай толилуулгыг НББОУС12-ын дагуу бэлтгэдэг	3.492	.001	.377	.16	.59
Бараа материалын үнэ цэнийн бууралтыг тооцож, зөрүүг НББОУС12-ын дагуу бүртгэдэг	-.505	.615	-.065	-.32	.19
Бараа материалын анхдагч хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	-.104	.917	-.013	-.26	.24
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох арга нь татварын хуулиар тогтоосон аргаас ялгаатай байдаг	2.730	.008	.364	.10	.63
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа татварын хуулиар тогтоосон хугацаанаас ялгаатай байдаг	4.634	.000	.558	.32	.80
Үндсэн хөрөнгийн анхдагч хэмжилттэй холбоотой зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	9 2.041	.045	.260	.01	.51

Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус ашиг, алдагдлаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	6.136	.000	.675	.46	.89
Орлогыг СТОУС15-ын дагуу бүртгэж, НББОУС12-ын дагуу зөрүү үүсгэж бүртгэдэг	1.755	.083	.195	-.03	.42
ХОЗҮХХ-ийн дараа үеийн хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	.580	.563	.078	-.19	.35
Бэлтгэл ажиллагаа хугацаа шаардагдсан хөрөнгийг олж бэлтгэхэд зориулан авсан зээлийн өртгийн капиталжуулалтаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.119	.267	.143	-.11	.40
Ашиглах эрх бүхий хөрөнгөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	.505	.615	.065	-.19	.32
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	-.212	.833	-.026	-.27	.22
Нөөц болзошгүй өр төлбөрөөс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	-.971	.335	-.130	-.40	.14

Хүснэгт №4-ийн үр дүнг харвал таамаглал 2-той холбоотой 15 асуултаас тодоор тэмдэглэснээс бусад тооцооны t утга нь хүснэгтийн t утгаас өндөр байгаа тул асуултуудын дундаж хариулт хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байгааг харуулж байна.

Харин Бараа материалын үнэ цэнийн бууралт болон анхдагч хэмжилтээс зөрүү тооцож НББОУС12-ын дагуу бүртгэдэг, ХОЗҮХХ-ийн дараа үеийн хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг, Бэлтгэл ажиллагаа хугацаа шаардагдсан хөрөнгийг олж бэлтгэхэд зориулан авсан зээлийн өртгийн капиталжуулалтаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг, ашиглах эрх бүхий хөрөнгөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг, нөөц болзошгүй өр төлбөрөөс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг гэсэн асуултуудын тооцооны t утга нь хүснэгтийн t утгаас бага байгаа тул асуултуудын дундаж хариулт хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа байхгүйг харуулж байна. Энэ нь байгууллагуудын СТОУС-ын хэрэгжилт тус стандартууд дээр төдийлөн ашиглагддаггүйгээс хамаараад Орлогын албан татварын бүртгэлээс зөрүү үүсгэх эсэх дээр ойлголтгүй байгаатай холбоотой байж болно.

Хүснэгт 5. НББОУС 12 “Орлогын татвар” стандартын дагуу татварын зөрүүг хүлээн зөвшөөрч, тайлагнах тухай асуултын дундаж болон стандарт хазайлт

№	№	Асуулт	Хариулт	Дүн
1	1	Татвар төлөхийн өмнөх ашиг болон татвар ногдуулах орлогыг зөрүүтэй тайлагнадаг	3.73	Өндөр
2	5	Тусгай хувь хэмжээтэй орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	3.69	Өндөр
3	7	Хасагдахгүй зардалтай холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	3.69	Өндөр
4	6	Хөнгөлөгдөх орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	3.6	Дунд
5	4	Чөлөөлөгдөх орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	3.58	Дунд
6	8	Хасагдах зардалд тавигдах шаардлагатай холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	3.55	Дунд
7	2	Хойшлогдсон татварын хөрөнгө бүртгэж тайлагнадаг	3.45	Дунд
8	3	Хойшлогдсон татварын өглөг бүртгэж тайлагнадаг	3.45	Дунд
9	9	Дундаж татварын түвшинг ашиглан хойшлогдсон татварыг зөв бүртгэж тайлагнадаг	3.03	Дунд
Дундаж			3.53	Дунд

Дээрх хүснэгтээс харахад татварын зөрүүг хүлээн зөвшөөрч тайлагнах байдал нь 3.03-3.73 хооронд үнэлэгдэж байна. Аж ахуйн нэгжүүд “татвар төлөхийн өмнөх ашиг болон татвар ногдуулах орлогыг зөрүүтэй тайлагнадаг” гэсэн асуулт нь хамгийн өндөр буюу 3.73

үнэлгээтэй гарсан байна. “Дундаж татварын түвшинг ашиглан хойшлогдсон татварыг зөв бүртгэж тайлагнадаг” гэсэн асуулт нь хамгийн бага үнэлгээтэй буюу 3.03 байна.

Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд нь НББОУС12-т нийцүүлэн байнгын болон түр зөрүүг бүртгэж тайлагнадаг гэсэн нэгдүгээр таамаглалын асуултын дундаж үнэлгээ 3.53 (дунд) гарсан. Энэхүү судалгаанаас харахад аж ахуй нэгж байгууллагууд байнгын зөрүү үүсгэх ажил гүйлгээ, үйл явдлын бүртгэл, тайлагнал сайн буюу дунджаар 3.6 (дунд) үнэлгээтэй гарсан. Харин түр зөрүүг бүртгэх асуулгуудын үнэлгээ 2.5-3.5 хооронд буюу дунд гарсан байна.

Хүснэгт 6. НББОУС12-т нийцүүлэн орлогын албан татварыг бүртгэдэг эсэх асуултуудын стандарт дундаж болон хазайлт

№	№	Асуулт	Хариулт	Дүн
1	9	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус ашиг, алдагдлаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	3.68	Өндөр
2	7	Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа татварын хуулиар тогтоосон хугацаанаас ялгаатай байдаг	3.56	Дунд
3	2	Орлогын татварын бүртгэлтэй холбоотой шаардлагатай тодруулгыг НББОУС 12-ын дагуу бэлтгэдэг	3.45	Дунд
4	3	Орлогын татварын бүртгэлтэй холбоотой шаардлагатай толилуулгыг НББОУС12-н дагуу бэлтгэдэг	3.38	Дунд
5	6	Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох арга нь татварын хуулиар тогтоосон аргаас ялгаатай байдаг	3.36	Дунд
6	1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлтийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтээс үүссэн татварын зөрүүг НББОУС 12-т нийцүүлэн бүртгэдэг	3.32	Дунд
7	8	Үндсэн хөрөнгийн анхдагч хэмжилттэй холбоотой зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	3.26	Дунд
8	10	Орлогыг СТОУС15-ын дагуу бүртгэж, НББОУС12-ын дагуу зөрүү үүсгэж бүртгэдэг	3.19	Дунд
9	12	Бэлтгэл ажиллагаа хугацаа шаардагдсан хөрөнгийг олж бэлтгэхэд зориулан авсан зээлийн өртгийн капиталжуулалтаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	3.14	Дунд
10	11	ХОЗҮХХ-ийн дараа үеийн хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	3.08	Дунд
11	13	Ашиглах эрх бүхий хөрөнгөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	3.06	Дунд
12	5	Бараа материалын анхдагч хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	2.99	Дунд
13	14	Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	2.97	Дунд
14	4	Бараа материалын үнэ цэнийн бууралтыг тооцож, зөрүүг НББОУС12-н дагуу бүртгэдэг	2.94	Дунд
15	15	Нөөц, болзошгүй өр төлбөрөөс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	2.87	Дунд
Дундаж			3.22	Дунд

Дээрх хүснэгтээс харахад Таамаглал 2: Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд нь НББОУС12-т нийцүүлэн орлогын албан татварыг бүртгэдэг гэсэн бүлэг асуултын дундаж үнэлгээ 3.22 (дунд) үнэлгээтэй байна.

Аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус ашиг, алдагдал болон үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа татварын хуулиар тогтоосон хугацааг ялгаатай тогтоосноос үүсэх зөрүүг НББОУС12-т нийцүүлэн бүртгэх нь харгалзан 3.68 (өндөр) болон 3.56 (дунд) үнэлгээтэй байна.

ДУГНЭЛТ

Бид НББОУС 12 “Орлогын албан татвар” стандартын хэрэгжилтийг үнэлэхийн тулд 3 бүлэг бүхий асуулга боловсруулан аудитор болон аудиторын туслахуудыг судалгаанд хамруулсан.

Бидний судалгааны үр дүнд татварын зөрүүг бүртгэж тайлагнах байдал нь үнэлгээ өндөр гарсан ч үүнд түр зөрүү буюу хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг бүртгэж тайлагнах нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, тусгай хувь хэмжээтэй орлого, хасагдахгүй зардлаас хамаарсан байнгын зөрүүг бүртгэж тайлагнахтай харьцуулахад бага үнэлгээтэй байсан.

Мөн гадаад валютын ханшийн өөрчлөлт болон үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаанаас үүссэн зөрүүг НББОУС12-ийн дагуу бүртгэж тайлагнах байдал нь бусад зөрүү үүсэх нөхцөлүүдээс хамгийн өндөр үнэлэгдсэн. Харин бараа материал, хөрөнгө оруулалт, нөөц өр төлбөрийн хэмжилтээс үүсэх түр зөрүүг НББОУС12-ын дагуу бүртгэх тайлагнах байдал хамгийн бага үнэлгээтэй байгаа ч бидний тогтоосон шалгуурын хувьд НББОУС12-ын хэрэгжилт дундаж байна.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАЛТ

- Судалгаанд аудитор болон аудиторын туслахуудыг хамруулсан. Иймд судалгааны үр дүн тэдний мэргэжлийн шийдэлд үндэслэгдсэн.

ЦААШИД СУДЛАХ БОЛОМЖУУД

- Топ аудитын компаниудын туршлагатай аудиторуудтай фокус ярилцлага хийх байдлаар тус стандартын хэрэгжилтийг үнэлэх
- Бусад стандартын хэрэгжилтийг судлах

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Abdallah, A. A. (2017). The Conformity Level of Income Tax Accounting In Jordan with the Requirements of the International Accounting Standard IAS (12) in Terms of Taxable Temporary Differences' Recognition . *International Business Research*.
- Anna Görnitz, Michael Dobler. (27 September 2021). Financial accounting for deferred taxes: a systematic review of empirical evidence . *Published online*.
- Chiladze, I. (2017). “International Accounting Standard 12 –“Income Tax” and Aspects for Discussion”. *Applied Finance and Accounting*.
- ISA. (2009). *ISA200*.
- Jude, E. (2022). “Analyses of Unintended Consequences of IAS 12 Adoption on Deferred Taxes” .
- Nanhee Hong, Junyong Shim. (2019). “The Effect of the Adoption of International Accounting Standards No. 12 (IAS No. 12) for Firms Reporting Losses: Evidence from Korea.
- Ogbodo Cy. Okenwa, Egbunike Francis Chinedu, Abiahu Mary-Fidelis Chidoziem. (2017). “Assessment of Deferred Tax Recognition and Measurement under IFRS and Nigeria-SAS: An Empirical Examination” . *Asian Journal of Economics, Business and Accounting*.
- Patrick Amaechi Egbunike, Onyii Paulinus Okoye. (2017). Tax Implication of International Accounting Standards (IAS 12) Adoption: Evidence from Deposit Money Banks (DMBS) in Nigeria. *International Journal of Social and Administrative Sciences*, 52-62.
- Prem W.S. Yapa, Diane Kraal Monash, Mahesh Joshi. (2015). The adoption of ‘International Accounting Standard (IAS) 12 Income Taxes’: Convergence or divergence with local accounting standards in selected ASEAN countries?
- Purina, M. (2017). “Deffered tax under IAS12 in the chosen Czech and Russian companies” . *Procedia - Social and Behavioral Sciences*.
- Tucker-Seeley, K. R. (2008). *The Effects of Using Likert vs. Visual*.
- ААНОАТ-ын тухай хууль. (2019 оны 03 22). *legalinfo.mn*.
<https://legalinfo.mn/mn/detail/14407-ээс> Гаргасан
- Г.Алтанзаяа. (2008). Санхүүгийн тайлан, татварын тайлангийн зөрүүг зохицуулан бүртгэх нь. *Үндэсний татварын албаны онол, практикийн бага хурал*.
- Л.Дондог. (2017). СТОУС-ыг цэгнэхүй. *Journal of the Accounting Theory and Practice*.
- МНБИ. (2021). *СТОУС А. УБ*.
- Х.Нямбаяр, Ц.Намуун. (2023). “Монгол улсын аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлагнал дахь үнэлгээний асуудал”. *ММНБИ СРА сэтгүүл*.
- хууль, А.-ы. т. (2019 оны 07). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. *Legalinfo.mn*:
<https://legalinfo.mn/mn/detail/14407-ээс> Гаргасан

Sig	Pearson Correlations																									
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24		
1	1																									
2	.469**	1																								
3	.476**	.858**	1																							
4	.192	.245*	.317**	1																						
5	.293**	.244*	.337**	.655**	1																					
6	.056	.286*	.359**	.636**	.601**	1																				
7	.300**	.226*	.333**	.716**	.593**	.579**	1																			
8	.252*	.236*	.336**	.718**	.509**	.538**	.726**	1																		
9	.301**	.546**	.640**	.257*	.279*	.459**	.193	.335**	1																	
10	.300**	.502**	.553**	.073	.042	.308**	.055	.147	.667**	1																
11	.328**	.530**	.590**	.086	.191	.260*	.169	.054	.459**	.604**	1															
12	.291*	.388**	.452**	.222	.179	.360**	.196	.166	.458**	.689**	.693**	1														
13	.230*	.511**	.559**	.076	.026	.374**	.081	.203	.667**	.773**	.624**	.603**	1													
14	.215	.401**	.511**	.220	.030	.229*	.233*	.325**	.596**	.626**	.454**	.551**	.767**	1												
15	.351**	.319**	.434**	.270*	.307**	.320**	.356**	.339**	.295**	.249*	.387**	.291*	.387**	.374**	1											
16	.353**	.355**	.435**	.220	.221	.246*	.355**	.263*	.270*	.208	.284*	.300**	.318**	.336**	.813**	1										
17	.253*	.284*	.395**	.301**	.100	.287*	.345**	.382**	.400**	.376**	.337**	.242*	.421**	.498**	.663**	.611**	1									
18	.406**	.440**	.526**	.263*	.377**	.370**	.373**	.382**	.396**	.291*	.411**	.366**	.403**	.370**	.642**	.682**	.555**	1								
19	.337**	.460**	.520**	.231*	.120	.368**	.123	.223	.596**	.651**	.463**	.562**	.659**	.583**	.503**	.455**	.461**	.544**	1							
20	.252*	.511**	.608**	.047	.029	.178	.061	.052	.551**	.568**	.562**	.563**	.637**	.623**	.371**	.355**	.354**	.427**	.640**	1						
21	.157	.341**	.461**	.072	.015	.324**	.082	.173	.500**	.580**	.475**	.544**	.580**	.484**	.432**	.332**	.496**	.396**	.577**	.659**	1					
22	.416**	.324**	.378**	.230*	.284*	.374**	.258*	.369**	.488**	.468**	.307**	.482**	.479**	.438**	.431**	.499**	.436**	.515**	.491**	.481**	.555**	1				
23	.239*	.402**	.467**	.139	.139	.347**	.176	.277*	.524**	.448**	.467**	.488**	.628**	.592**	.384**	.302**	.290*	.372**	.470**	.697**	.603**	.533**	1			
24	.281*	.473**	.561**	.103	.184	.316**	.093	.225*	.557**	.500**	.448**	.483**	.630**	.624**	.342**	.261*	.297**	.322**	.494**	.730**	.715**	.623**	.831**	1		
	.013	.000	.000	.371	.110	.005	.419	.049	.000	.000	.000	.000	.000	.000	.002	.022	.009	.004	.000	.000	.000	.000	.000	.000	1	

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

* . Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

ХАВСРАЛТ: Таамаглал 1-той холбоотой Factor analysis-ийн үр дүн

KMO and Bartlett's Test

Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.790
	Approx. Chi-Square	410.572
Bartlett's Test of Sphericity	df	36
	Sig.	.000

Communalities

	Initial	Extraction
Татвар төлөхийн өмнөх ашиг болон татвар ногдуулах орлогыг зөрүүтэй тайлагнадаг	1.000	.417
Хойшлогдсон татварын хөрөнгө бүртгэж тайлагнадаг	1.000	.827
Хойшлогдсон татварын өглөг бүртгэж тайлагнадаг	1.000	.869
Чөлөөлөгдөх орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	1.000	.803
Тусгай хувь хэмжээтэй орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	1.000	.631
Хөнгөлөгдөх орлоготой холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	1.000	.633
Хасагдахгүй зардалтай холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	1.000	.753
Хасагдах зардалд тавигдах шаардлагатай холбоотой байнгын зөрүүг тайлагнадаг	1.000	.704
Дундаж татварын түвшинг ашиглан хойшлогдсон татварыг зөв бүртгэж тайлагнадаг	1.000	.584

Extraction Method: Principal Component Analysis.

Total Variance Explained

Component	Initial Eigenvalues			Extraction Sums of Squared Loadings			Rotation Sums of Squared Loadings		
	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %
1	4.413	49.031	49.031	4.413	49.031	49.031	3.491	38.789	38.789
2	1.809	20.097	69.128	1.809	20.097	69.128	2.730	30.339	69.128
3	.882	9.796	78.924						
4	.537	5.970	84.894						
5	.479	5.324	90.218						
6	.308	3.425	93.642						
7	.250	2.783	96.426						
8	.202	2.244	98.669						
9	.120	1.331	100.000						

Extraction Method: Principal Component Analysis.

Таамаглал 2-той холбоотой Factor analysis-ийн үр дүн

KMO and Bartlett's Test

Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.858
Approx. Chi-Square		883.961
Bartlett's Test of Sphericity	df	105
Sig.		.000

Communalities

	Initial	Extraction
Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлтийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтээс үүссэн татварын зөрүүг НББОУС 12-т нийцүүлэн бүртгэдэг	1.000	.807
Орлогын татварын бүртгэлтэй холбоотой шаардлагатай тодруулгыг НББОУС12-ын дагуу бэлтгэдэг	1.000	.667
Орлогын татварын бүртгэлтэй холбоотой шаардлагатай толилуулгыг НББОУС12-ын дагуу бэлтгэдэг	1.000	.711
Бараа материалын үнэ цэнийн бууралтыг тооцож, зөрүүг НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.000	.780
Бараа материалын анхдагч хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	1.000	.629
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох арга нь татварын хуулиар тогтоосон аргаас ялгаатай байдаг	1.000	.811
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа татварын хуулиар тогтоосон хугацаанаас ялгаатай байдаг	1.000	.834
Үндсэн хөрөнгийн анхдагч хэмжилтэй холбоотой зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	1.000	.651
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус ашиг, алдагдлаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.000	.695
Орлогыг СТОУС15-ын дагуу бүртгэж, НББОУС12-ын дагуу зөрүү үүсгэж бүртгэдэг	1.000	.655
ХОЗҮХХ-ийн дараа үеийн хэмжилтээс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.000	.723
Бэлтгэл ажиллагаа хугацаа шаардагдсан хөрөнгийг олж бэлтгэхэд зориулан авсан зээлийн өртгийн капиталжуулалтаас зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.000	.661
Ашиглах эрх бүхий хөрөнгөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.000	.601
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс зөрүү үүсгэж НББОУС12-ын дагуу бүртгэдэг	1.000	.809
Нөөц болзошгүй өр төлбөрөөс зөрүү үүсгэж НББОУС 12-ын дагуу бүртгэдэг	1.000	.915

